

МОНГОЛ УЛСЫН ГУРАВДАГЧ ХӨРШИЙН БОДЛОГО & ХОЁР ХӨРШ

*Тус хүрээлэнгийн судлаач-профессор,
Элчин сайд асан Дашидоржийн Баярхүү*

1. Оршил

Монгол Улс хил залгаа хоёрхон хөрштэй. Газар зүйн ба геополитикийн гарцаагүй бодит тулгалт, түүхэн хувь заяа бол энэ мөн. Олон мянганы түүхийн нугачаан дунд буй болсон бодит үнэнтэй монголчууд дасан зохицож, зөвшөөрч, мөн хөрвөж, гарц хайж ирсэн нь үнэн билээ. Монгол Улсын оршин байх, хөгжин дэвжих, уруудан доройтох, тэсч үлдэх, эргэж сэргэх бүх түүхэн процесс нь энэ хоёр хөрштэйгээ хэр харилцаж ирэв гэдгээс ихээхэн шалтгаалж ирсэн. Ялангуяа XX зуунд энэ түүх үүнийг нотлон харуулсан.

Энд миний өгүүлэх үндсэн санаа бол гуравдагч хөршийн бодлогоо тууштай явуулахын тулд хоёр хөрш орондоо байнга тайлбарлаж, төр-засагт нь байр сууриа албан ба албан бусаар (I суваг, I хагас суваг, II суваг) илэрхийлж байх хэрэгтэй. Үүнд албан ёсны байр суурь томъёолсон бодлогын баримт бичиг ГХЯ-наас боловсруулж, ҮАБЗ-д өргөн бариад, ҮАБЗ-өөс зөвлөмж гаргаж мөрдүүлж болно. Гуравдагч хөршийн талаар хоёр хөрш улсын төр-засагт нь байнгын хөдлөшгүй үзэл бодол бид төлөвшүүлэх хэрэгтэй. Үүнд дипломат алба ихээхэн үүрэгтэй ажиллана. ГХЯ-ны нэг үндсэн үүрэг нь гуравдагч хөршийн бодлогоо сурталчлан таниулах үйл ажиллагаа байна. Зөвхөн сурталчлан таниулаад зогсохгүй гуравдагч хөрш оролцсон төслүүд

хоёр хөршид аюул занал учруулахгүй гэдгийг нотлож, зарим төсөлдөө урьж болно гэдгийг эл өгүүлэлдээ буулгалаа.

Монгол-Орос-Японы гурвалсан төслөөр Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах, хэтдээ түүнийгээ эдийн засгийн чөлөөт бүс, тойрог болгох, түүндээ БНХАУ-ыг татаж оролцуулах нь эдийн засгийн аюулгүй байдлаа бэхжүүлэх, мөн Хятадын бодлогод Монголын эдийн засгийн ач холбогдлыг өргөж өгөхөд нэмэртэй хэмээн үзэж байна. Түүхий эдээ түүхий чигээр нь зөвөөрлөдөг бус Монгол-Орос-Японы гурвалсан төслөөр түүнийгээ боловсруулан нэмүү өртөг шингээн Хятадын худалдан авагчдад хүргэх талаар ажиллах нь чухал юм. Тэгвээс Хятадын хил залгаа мужууд, Өвөр Монголын бүс нутгуудын эдийн засгийн ашиг сонирхлыг Монголдоо бий болгож чадна. Монгол-Орос-Японы гурвалсан төсөлд Хятадыг урих, мөн Монгол-Канад-Хятад, Монгол-Солонгос-Хятад, Монгол-Австрали-Хятад гэх мэтээр гурвалсан эдийн засгийн төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаа хийж, бодит саналаа боловсруулах нь зөв биз ээ. Энэ талын судалгаа, саналаа Хятадтай зөвлөлдөж гүйцэтгэж ч болох мэт.

Нөгөө талаасаа, түүх сөхвөл Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого хоёр хөршөөс дэмжигдэхгүй байх магадлал өндөр байж ирсэн. Монгол Улсын хөгжил дэвшил жигдрээгүй сул дорой байсаар ахул бүр ч дэмжигдэхгүй байх болов уу. Хэзээ дэмжигдэх вэ гэвэл Монгол Улс хөгжлийн замдаа жигдэрч, монголчууд дэлхийн дундаж амьдралтай, хэнээс ч царай алдахгүй болсон цагт аяндаа дэмжигдэнэ.

Гэхдээ энэ хоёр хөрштэйгээ сайн харилцаатай байх нь юу юунаас чухал гэдгийг XX зууны үеийн хоёрдугаар хагасын түүх бэлхнээ хэлж өгсөн. Энэ хоёр улстайгаа сайн харилцаатай байх хэрэгтэй гэдэг санааг анхлан гуравдагч хөрш орнуудын төлөөлөгчдөөс анх удаа АНУ-ын сенатч Алан Крэнстон тухайн үеийн БНМАУ-д айлчлахдаа мэдэгдсэн, зөвлөсөн ¹.

¹ Алан Крэнстон бол Монголд айлчилсан АНУ-ын анхны сенатч, Сенатын Гадаад харилцааны хорооны Зүүн Ази, Номхон далайн салбар хорооны дарга. Тэрээр 1987 оны 8 дугаар сард Монгол Улсад айлчилснаараа 1944 онд АНУ-ын Дэд ерөнхийлөгч БНМАУ-д айлчилснаас хойшхи 40 гаруй жилд Монголд анх удаа ирсэн, мөн 1987 оны эхээр Монгол-АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны дараа АНУ-аас Монголд зочилсон албан ёсны, анхны өндөр хэмжээний төлөөлөгч болсноороо онцлог байв –

“Цаг үе” сэтгүүл, 1987.08.30 № 24/60/

“Хүйтэн дайн” шувтрах үест БНХАУ-тай харилцаагаа аажмаар сайжруулж, хоёр талдаа айх аюулгүй гадаад таатай орчныг бүрдүүлж чадсан ба хоёр хөрштэй тогтоосон харилцааны хүрээндээ явцууралгүй, бусад тив, дэлхийтэй өргөн харилцаатай байх бодит эхлэлийг тавьсан. Тэр зурвас үеийн түүхэн боломжийг ардчилал руу шилжиж байсан Монгол зөв тавьж чадсан. Хоёр хөршөөсөө гадна гуравдагч хөрштэй болох нь чухал (бүр ч чухал) гэдгийг 1990-ээд оны эхэн үеийн Монголын төр засаг, улс төрийн намууд зөвөөр олж харж, байр сууриа зөвөөр томъёолсон. Үүнд Ж.Бейкер, Т.Кайфу нарын айлчлал түүхэн сэдлийг өгсөн болно.

Гэхдээ “Турав дахь хөрш”-ийн тухай ойлголт нь шинэ тутам гарч ирсэн санаа биш. Монгол Улс түүхэндээ “Турав дахь хөрш”-өө эрж хайж байсан цаг үе бий бөгөөд харин ингэж цэгцтэй ойлгох, томъёолох талаар оролдого хийж байсангүй. Уг үзэл баримтлалын гол агуулга нь Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино².

2. Түүхэн газар зүйн эрхшээл

Европчуудыг Азид, азийнхныг Европт хамгийн анх, үнэн мөнөөр нь, хамгийн өргөн хүрээнд танилцуулсан улс үндэстэн бол монголчууд билээ. Ази гэдгээр энд Төв ба Зүүн Азийг хэлсэн хэрэг. Монголчууд XIII-XIV зуунд Евразийн өргөн уудам нутагт байлдан дагуулалт хийхдээ, соёл, хүмүүнлэг, иргэншил, мэдээллийн асар том түүхээгийн үүрэг давхар гүйцэтгэсэн юм.

Хятадын “торгоны зам” жинхэнэ утгаараа Монголын их эзэнт гүрний үед цэцэглэж байжээ. Тэр замын дагуухи аюулгүй байдал, дэг журам, худалдаа арилжааны соёлыг монголчууд сахиулж байлаа. Ираны персийн соёл шашны мөхөөгдөх аюулаас чухам монголын Ил хаад л авралын гараа сунгасан тухай ираны түүхэнд өгүүлдэг. Өнөөгийн

² Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, 11 дэх талд



Орос бол европын гэхээсээ евразийн өвөрмөц соёлтой, тэр соёлынх нь өвд Оросын нутагт ноёлж байсан Монголын Алтан ордны улсын ул мөр, нөлөө багагүй үүрэг гүйцэтгэсэн. Үнэндээ Оросыг монголчууд л нэгтгэж, нэг төрт-улс болох эхийг нь тавьсан юм. Хятадын түүхнээ Хятадын олон хаант улсуудыг монголчууд л нэг тугийн дор нэгтгэж, нийслэл Бээжинг нь Монголын Юань гүрэн хойшдын Мин, Чин, ДИУ, БНХАУ-ын нийслэл болгох үндсийг тавьсан юм. Энэ мэт ярьвал Евразийг дамнасан улс үндэстэн, овог аймгуудын их нүүдлийг монголчууд, тэдний өвөг болох хүннү нар өдөөсөн билээ.

Монгол Улсын газар зүйн байршлыг газрын зурагнаас харвал баруунаас зүүн тийш сунаж тогтсон, өвөрмөц байршилтай улс юм. Газар зүйн сунаж тогтсон тэрхүү хэвтээ байршлыг ажваас Монгол нь Төв Ази ба Зүүн хойд Азийг, өргөн утгаар Өрнө-Дорныг холбогч эх газрын нэгэн гүүр юм. Умаршаа ба өмнөшөө байршил нь яалт ч үгүй Орос-Хятадын завсарт орших геостратегийн онцгой байршил гэж тооцогдож ирсэн. Тэр өнцгөөс авч үзвэл энэхүү онцгой байршил нь Монголын үе үеийн улс төрчдийн хувьд гуравдагч хөршийг хүсэмжлэхээр юм.

Түүхэндээ Монголыг XX зууны эхний хагаст Орос-Японы³, дараа

³ Русско-Японское Соглашение 1907 по общеполит. вопросам (Секретная часть) Дипломатический словарь, II том, Москва, 1985, 496 дахь талд; Русско-Японская Конвенция 1912 (секретная) мөн ботийн 497 дахь талд,

нь Зөвлөлт-Японы⁴, мөн Орос-Хятадын⁵, Зөвлөлт-Хятадын⁶, хоёр дахь хагаст Зөвлөлт-Хятадын завсарт орших буфер бүс, жийргэвч үздэг байсан ба тэр утгаар XX зууны Монголын гадаад орчин бүрдэж, Монголд тохиосон хувьсгал, тэмцэл, хэлмэгдэл, Халхын голын дайн, Монголын статус-квог хүлээн зөвшөөрсөн, социалист бүтээн байгуулалт, Зөвлөлт-Хятадын 30 жилийн зөрчил, дагалдаад Монгол-Хятадын 20 гаруй жилийн зөрчил, “Хүйтэн дайн”-д Монгол нь СССР тэргүүтэй коммунист эвслийн дорнод жигүүр болж явсан гэхчлэн их түүх өрнөж байсан билээ.

Хоёр жилийн тэртээ Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улс байнга төвийг сахих тухай санаачилга дэвшүүлсэн “Монгол-Төвийг сахих”⁷ гэсэн бүхий нийтлэл бичиж, улмаар ҮАБЗ-ийн 39/21 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэхээр дараахан нь Монгол Улсын Засгийн газраас 9 дүгээр сарын 14-нд № 375 тогтоол (Зөвлөмж дэмжих тухай) батлах үед өрнөсөн хэлэлцүүлэгт хоёр хөрш ингэхэд хэн бэ, хэн байцгаав гэсэн сэдэв хөндөгдсөн. “Төвийг сахих Швейцарь загвар Монголд тохирохгүй (Ранжан Гупта)” хэмээн бичсэн эшлэлийг би эш татан тэрхүү мэтгэлцээнд оролцсон. Юу гэвэл тэрхүү энэтхэг эрдэмтэн ингэж үзсэн: Швейцарийн хөршүүд түүнд хандаж байсан шиг Монголын хоёр хөрш Монголд тэгж хандаж байгаагүй; Төвийг сахина гэдэг нь тэр улс төвийг сахих амлалтдаа зайлшгүй үнэнч байхын сацуу эргэн тойрных нь улсууд хууль тогтоомж, үзэл баримтлалаараа төвийг сахисныг нь хүндэтгэсэн байх учиртай; Тэгвэл тийм хүндэтгэлийг бүрэн эрхт улсынх нь хувьд Монголд хоёр хөрш нь хэзээ ч үзүүлж ирээгүй гэжээ⁸. Энэ бол 1998 онд энэтхэг эрдэмтэн Ранжан Гуптагийн

4 Советско-Японское Соглашение 1939 о прекращении военных действий в р-не Халхин-Гола, Дипломатический словарь, III том, Москва, 1985, 369 дэх талд; Советско-Японский Пакт 1941 о нейтралитете, мөн боть, мөн тэр талд

5 Русско-Китайская Декларация 1913, Сборник договоров России с другими государствами, 1856-1917, Москва, 1952, 410-417 дахь талд

6 Советско-Китайское Соглашение 1924 об Общих принципах для урегулирования вопросов между Союзом ССР и Китайской Республикой, Дипломатический словарь, III том, Москва, 1973, 296-297 дахь талд; Советско-Китайский Договор 1937 о ненападении, Дипломатический словарь, III том, Москва, 1985, 209 дэх талд; Советско-Китайский Договор 1945 о дружбе и союзе (нот), мөн ботгийн 209-210 дахь талд

7 <http://www.president.mn/>; <http://politics.news.mn/content/221667.shtml>

8 Евразийн геополитик, олон улсын харилцаа: Өнгөрсөн, одоо, ирээдүй

(PhD горилж нэмж засварласан хоёр дахь хэвлэл), МУИС, ОУХС, 2003, 2005, 258 дахь талд

анхааруулах зөвлөх байдлаар бидэнд хандаж хэлсэн, Монгол-Энэтхэгийн эрдмийн II бага хуралд түүний хэлэлцүүлсэн илтгэл дэх мөрүүд юм. Эндээс ямар дүгнэлт хийхэв гэвэл хоёр хөрш нь Монголд ямагт өршөөлгүй хандаж ирсэн, хандах ч юм байна гэсэн сэтгэгдэл буух болов уу.

1990-ээд онд “Хүйтэн дайн” төгсөж, СССР гүрэн тарж, коммунизм байгуулах зорилт нурсны дараа Монгол Улсад цоо шинэ боломжууд нээгдсэн. Тэр утгаар хоёр хөрш гүрний өршөөлгүй байх тэр хандлага түр саарсан буюу зогссон байх талтай. Монгол нь цоо шинэ гадаад орчинд биеэ даасан, ардчилсан, зах зээлийг баримжаалсан дотоод бодлогоо хэрэгжүүлэх гадаад шинэ орчныг эрэлхийлсэн, түүндээ ч хүрсэн, тийм гадаад таатай нөхцлийг бүрдүүлж чадсан билээ.

Хоёр зууны зааг үед олон улсын харилцаа улам хурдтай хувирсан. Олон улсын харилцааг их гүрнүүдийн улс төрийн бодлогын тэнцвэр хангаж ирсэн тэр байдал аажмаар өөрчлөгдөж, дэлхий хавтгай болж, дэлхий дахинаараа мэдээлэлжин, даяаршил хурдтай өрнөж байгаа өнөө цагт Монгол Улсын ба Монголын газар зүй-геополитикийн байршлын ач холбогдол улам өсч байна. Ази-Европ, Европ-Номхон далайн дунд орших агаарын тээврийн хамгийн “алтан байрлал” бүхий улс бол Монгол юм.

Мэдээлэлжсэн даяаршсан өнөөгийн ертөнцөд “арал” гэх газар зүйн ойлголт геополитикийн өнцгөөс өнгө төрхөө өөрчилжээ. Ямар хүрээлэл дунд байна гэдгээр нь “арал” хэмээх ойлголт буй болдог болжээ. Freedom House хэмээх ардчиллын рейтингийн судалгаа хийдэг олон улсын байгууллагын судалгаагаар ардчилсан, хагас ардчилсан, харгис, дарангуйлах дэглэмтэй хэмээн дэлхийн бүх улс орныг өнгөөр ялган тэмдэглэсэн газрын зурагт нь арал мэт эргэн тойрны хар бараан, хар саарал өнгөн дотор гялтайгаад байж байдаг. Тэр гялтгарыг “арал” хэмээн нэрлэнэ. Өмнө талдаа коммунист дэглэмтэй, нэг намын хатуу засаглалтай тоталитари нэг гүрэн, умард этгээдэд хагас ардчилсан, ардчилаасаа ухарч буй бас нэг гүрэн, ийм хүрээлэл дунд ардчиллын толь болсон Монгол орших нь “арал” гэж хэлэгдэх, тэр нь эерэгээр үнэлэгдэх үндэс болно⁹.

9 Ардчиллыг хөзөр болгох хувь тохиол, “Засгийн газрын мэдээ”, 2015.09.10 № 171 (195)

“Арал Монгол”-ыг нөгөө талаас нь “Нейтраль Монгол” буюу “төвийг сахисан Монгол” хэмээн нэрлэх байдал ч мэр сэр үзэгдэх болжээ. Үндэслэл нь Монгол бол газар зүйн байршлын хувьд “нейтраль бүс” гэдэгт байна. Юу гэвэл Зүүн хойд Ази, Зүүн Ази, мөн Төв Азийн голд нь оршиж буй ардчилсан, нээлттэй, тогтвортой улс. Цэрэгжсэн, зэвсэглэсэн, өрнөдтэй сөргөөцөлдөх стратеги бүхий хоёр гүрний завсарт, дэлхийн хамгийн их цэрэгжсэн бүс нутгийн голд жижиг Монгол нь аргагүй л төвийг сахин оршиж байна.

Өрнө-Дорныг холбох “Нейтраль Монгол”-ын тухай бид бишгүй ярьдаг. Монголоос суралцахыг ч өрнөдийн ардчилсан улс гүрнүүд (гуравдагч хөршүүд) уриалан дууддаг, үүндээс биднийг лоббиддог болсон. Монголын жишгээр Азид Киргиз, Мьянмар ардчиллын төлөө явж байгаа гэж үздэг. Тэдний араас Афганистан, Балба, Бутан, Лаос, Камбож, улмаар Хойд Солонгос ардчиллын замаар явах ирээдүйн төлөв буй гэсэн яриа таамаг жилийн өмнө цухалзаж байсан. Эдгээр орнуудад Монголыг үлгэр жишээ, багш болгоно хэмээн үзсэн¹⁰. Скандинаваас Мьянмар руу Монголоор дамжин очих, үүнд Монголын “нейтраль бүс” чухал давуу тал болно хэмээн ярих нь буй. Баруун Европ, Умард Америкаас Бирм рүү хийх гео-улс төрийн их нүүдэлд нь ардчилсан Монгол гол трамплин болж болно гэсэн таамаг, саналууд ч цухалздаг.

Ийнхүү нейтраль байршилтай Монголын хувьд гуравдагч хөрш рүү хандах, тэдэнтэй ашиг сонирхлын (шинээр ардчилсан буюу ардчиллыг сэргээсэн улс орнуудын хамтын нийгэмлэг гэх мэт) сүлжээнд орох бэлээхэн хөрс бүрэн бүрдсэн хэмээн үзнэ.

3. “Швейцарь лугаа” гэх Ж.Цэвээний онол – Гуравдагч хөршийн бодлого

Гуравдагч хөрштэй болох гэсэн үзэл бодол 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалтай давхцан Монголын нийгмийн тэргүүний хэсгийнхний дунд буй болсон хэмээн үздэг. Шинэ тулгар Богд хаант Монгол Улсын маань дипломат албаны эн тэргүүний зорилт нь хоёр хөрш болон их гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх,

¹⁰ Мөн тэнд

Өвөр чуулганыг Халхад нэгтгэн үндэсний нэгдмэл улс байгуулах явдал байсан.

1912 оны 11 дүгээр сарын 18-нд Монгол Улсын ГХЯ-наас ноот бичиг үйлдэж Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (Герман), Мэй (АНУ), Билиш (Бельги), Бин (Япон), Дан Ма (Дани), Хэ Лан (Холланд), Ау (Австри) зэрэг 9 улс гүрний ГХЯ-нд Харбин дахь тэдгээр орны консулуудад хандан Хөлөн буйрын сайдаар дамжуулан өгчээ. Уг ноот бичигт дурдагдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож Орос-Монголын хэлэлцээр лугаа «харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгамуу» гэсэн саналыг дэвшүүлж байсан¹¹.

Манжаас салж тусгаар тогтнолоо олж авчихаад түүнийгээ зөвшөөрүүлэх (Төвдийг эс тооцвол) гэж манай эх оронч ноёд Петербург орж, гадаад улсуудын Элчин сайдын яамдын түгжээтэй хаалгыг мөргөж, үүднийх нь харуулыг төрийн одонгоор хахуульдаж явсан гашуун түүхийг архиваас ухаад үзэж болно.

Энэ бүхэн нь Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын эхлэл, олон улсын харилцааны эрх зүйн субъект байх чадвар бүхий этгээд болохоо нотлон харуулсан анхны алхам байсан болов уу. Гуравдагч хөршийг хүсэмжилсэн дипломат чармайлтыг Хиагтын гурван улсын гэрээгээр¹² үндсэнд нь хязгаарласан нь гуравдагч хөршийн бодлого хоёр хөршөөс дэмжлэг огт хүлээхгүйн эхний томхон нотолгоо байлаа.

Хожмоо Ардын хувьсгал ялж, Ардын засаг тогтсоны дараа Ж.Цэвээнээс (тэрээр 1912 оны эхээр Гадаад яамнаа соёлын асуудал эрхэлсэн туслах түшмэлээр Буриадаас уригдан ирж байсан) гуравдагч хөршийн үзэл бодлоо төвийг сахих улс байгуулахыг уриалах хэлбэрээр илэрхийлэгдэж тэр нь төр-засгийн зүгээс зарим дэмжлэг хүлээж байжээ. “Монгол Улс болбоос СССР, Хятад хоёр улсаас баталсан бөгөөд бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн төвийг сахих улс болох хэрэгтэй. Энэ нь үлгэрлэвээс Швейцарь улс лугаа адил болой”¹³

¹¹ Дипломат албаны маань тулгын чулуу ингэж тавигджээ, <http://bayarkhuu.niitlech.mn/content/3629.shtml>, 2011 оны 12 сарын 21

¹² Русско-Китайско-Монгольское Соглашение 1915-Кяхтинское Соглашение, Дипломатический словарь, II том, Москва, 1985, 130 дахь талд

¹³ МАХН-ын товч түүх, УБ, 1985, 130 дахь талд

хэмээн 1926 онд Монголын тэрхүү их сэтгэгч бичиж байсан мөрүүд мартагдашгүй.

Тухайн үед Коминтерн ба Москвагийн оролцоотойгоор МАХН-ын зүүнтэн хэт хувьсгалчид нь Ж.Цэвээнийг баруунтны үзэл сурталч хэмээн хочлон дайрч, капиталист хүрээллийн нөхцөлд социалист (СССР), капиталист (Хятад) хоёр ертөнцийн хооронд төвийг сахих нь хувьсгалт Монгол улсыг империалистуудын идэш болгож, монгол ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг алдагдуулах аюулд хүргэнэ хэмээн туйлшруулж байжээ¹⁴. Энэ нь гуравдагч хөршийн бодлого хоёр хөршөөс дэмжлэг огт хүлээхгүйн бас нэг нотолгоо байлаа.

Төв Азидаа Швейцарь лугаа улс байгуулж, гуравдагч хөршөөр тусгаар тогтнолоо баталгаажуулах гэсэн үзэл бодол, оролдлого нь 1937 оны их хэлмэгдлийн үед японы тал баримтлах гэсэн, Японы империалистуудад урвах гэсэн бодлого болж гуйвуулагдан нуга дарагдсан билээ. Энэ тухай Ерөнхий сайд П.Гэндэнгээс Сталинд тайлагнасан баримт байна.

Гэндэн. Би Танаас БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлаар тайлбар тодруулга авмаар байх юм.

Сталин. Тусгаар тогтнолын тухайд, Танай улс үнэн хэрэгтээ тусгаар тогтносон улс юм. Миний мэдэж байгаагаар зөвхөн ЗСБНХУ л танай тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн. Тийм байх аа? Танайх албан ёсоор Хятадаас салаагүй, салснаа зарлан тунхаглаагүй. Тийм үү?

Гэндэн. Тийм ээ, тэр үнэн. ЗСБНХУ-аас өөр ямар ч улс биднийг хүлээн зөвшөөрөөгүй, Хятадаас албан ёсоор салаагүй.

Сталин. Танайд Хятадаас суугаа ямар нэгэн албан ёсны төлөөлөгч байна уу? Та бусад улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэхийг хүсч байна уу? Тэдгээртэй албан ёсны харилцаа тогтоохыг хүсч байна уу? Та бүхэн энэ сэдвээр бусад улсын төлөөлөгчидтэй

хэзээ нэгэн цагт ярилцаж байсан уу?

Гэндэн. Хятадын төлөөлөгч манайд байхгүй. Гадны хэн нэгнээр хүлээн зөвшөөрүүлэх гээгүй. Гадаадын ямар ч төлөөлөгчтэй би энэ сэдвээр ярилцаагүй.

Сталин. Тэгвэл гадаадынхнаар хүлээн зөвшөөрүүлэхийг Та хүсэхгүй байгаа хэрэг үү? Гадаадын ямар ч төлөөлөгчтэй энэ сэдвээр ярилцаагүй юм биз дээ?

Гэндэн. Тийм ээ. Би тэр тухай хэнтэй ч хэлэлцээ хийгээгүй. Гадаадаар, Японы зүгээс хүлээн зөвшөөрүүлэх гэсэн хүмүүсийг бид шийтгэснийг Та мэдэж байгаа.

Бид гадаадынхнаар хүлээн зөвшөөрүүлэх гэж эрмэлзэх хэрэг байгаа эсэхийг Та илүү сайн мэдэж байгаа биз ээ. Учир нь БНМАУ-ыг гадаад орнууд хүлээн зөвшөөрөх асуудал нь дотоодын биш, олон улсын чанартай юм¹⁵.

4. Дэлхийн II дайны дараахи гуравдагч хөршийн эрмэлзэл

Хэдийгээр умард хөрш СССР нь Монголыг гуравдагч хөрштэй байлгахгүй хэмээн дагуул улсын хувь тавиланг бидэнд тулгаж байсан боловч басхүү олон улсаар хүлээн зөвшөөрүүлэхийг уриалах явдал байсныг Сталины тэрхүү ярианы төгсгөл хэсгээс харж болно. Тэрээр:

- Та бүхэн олон улсаар хүлээн зөвшөөрүүлсэн цагт Танай орон албан ёсоор тусгаар тогтносон улс болно. Тийнхүү хүлээн зөвшөөрүүлэх гэж хөөцөлдөхөд буруу юм гэж үгүй. Юуны өмнө танайх Хятадаас хараат бус болсныгоо тунхаглавал зохино. Тусгаар тогтносон байдлаа Хятадын талаар зөвшөөрүүлж, бусад улс орнуудаар мөн тийнхүү хүлээн зөвшөөрүүлбэл Та бүхэн өвөр монголчууд буюу цахар, баргуудыг өөртөө татах болно. Тэгэх юм бол тэд Монголын жинхэнэ тусгаар тогтнол танайд байгаа юм байна гэж мэдэх болно.

¹⁴ МАХН-ын товч түүх, УБ, 1985, 130 дахь талд

¹⁵ Ерөнхий сайд П.Гэндэн тусгаар тогтнолын асуудлаар, Баримт: 1934.11.15, Москва, Кремль, Леонид Шинкарев. Цэдэнбал, түүний цаг үе: Хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл, УБ, 2006, хавсралт хэсгээс

- Та бүхэн бэхжиж, улсын хувьд хүчтэй болсон цагтаа Хятадаас хараат бус болсноо тунхаглах боломжтой болно. Тэгэх юм бол Япон, Англи зэрэг империалист улс орнууд өөрийнхөө санаачилгаар Та бүхнийг хүлээн зөвшөөрөх гэж эрмэлзэх болно¹⁶.

Монголын гуравдагч хөршийн бодлогод Ялтын бага хурал чухал түлхэц үзүүлснийг тэмдэглэх ёстой. Ялтын бага хурлын дараахи түүхэн үйл явдлуудын дүнд 1946 он гэхэд БНМАУ нь де-юре тусгаар тогтносон төрт-улс болж төлөвшөж эхэлжээ. ДИУ нь 1946.01.05-нд Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, 1946.01.13-нд дипломат харилцаа тогтоожээ. СССР-ийн хувьд де-факто болгож хувиргасан харилцаагаа 1945 онд де-юре болгоод харин хоёр талын ямар бичиг баримтаар баталгаажуулж, 1946.02.27-нд Москвад гарын үсэг зурсан Нөхөрлөл ба харилцан туслалцах тухай гэрээг¹⁷ үндэс болгов.

Энэ үеэс тэртээх 1912 оны эрмэлзлээ эргэж сэргээн дипломат харилцааны хойноос хөөцөлдөж эхэлжээ. Тэр нь ч гуравдагч хөршөө нэмэх гэсэн чармайлтын илрэл байлаа.

БНМАУ нь НҮБ-д элсэхээр өргөдөлөө 1946.06.21-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад өгсөн ба өргөдөл дэх хүсэлтээ тайлбарлахаар Монголын Засгийн газрын төлөөлөгчид 1945.08.28-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хуралд уригджээ. Хурал дээр Их Британийн төлөөлөгч Александр Кадоган (Alexander George Montagu Cadogan) Монголын талаар ийм яриа гаргасан байдаг:

- Монгол Ард Улс бол зөвхөн хоёрхон улстай дипломат харилцаатай бөгөөд энэ учраас олон улсын харилцаан дээр Монгол Ард Улсад дадлага туршлага хүрэлцэхгүй байна¹⁸.

16 Ерөнхий сайд П.Гэндэн тусгаар тогтнолын асуудлаар, Баримт: 1934.11.15, Москва, Кремль, Леонид Шинкарев. Цэдэнбал, түүний цаг үе: Хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл, УБ, 2006, хавсралт хэсгээс
17 БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл, I боть, УБ, 1964. Уг гэрээг 1946 онд байгуулж байхад БНМАУ ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд хэмээн сунжруу нэрээр бичиж байсан ба “нөхөрлөл” гэдгийг хожим “найрамдал” хэмээн эерүүлэн засчээ – Зохиогч

18 БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд аваагүйн үнэн шалтгаан (Улаанбаатар хотын намын идэвхтний хурал дээр тавьсан илтгэл, 1946.10.30), Ю.Цэдэнбал. Илтгэл, үгүүлэл, хэлсэн үг (Гурван боть түүвэр зохиол, I боть, 1941-1954 он), 235 дахь талд

Британийн дипломатчийн энэ яриаг Монголын төлөөлөгчдийн тэргүүн Ю.Цэдэнбал дараахан нь Улаанбаатарт намын идэвхтний хуралд тун оновчтой няцаасан байдаг. Тэрээр:

- Олон улсын харилцааны талаар байгаа бага ихийн хэмжээ бол НҮБ-ын гишүүнд ямар нэгэн улс орж чадах уу, үгүй юү гэж хэлэлцэгдэхэд нөхцөл болж чадах зүйл биш, НҮБ-ын гишүүнд элсэхэд тавигдах шаардлага ч биш болно¹⁹.

1948 онд хуралдсан МАХН-ын XI их хурал дайны дараахи Монголын гадаад харилцааны байдлыг анх удаа өргөн хүрээнд авч хэлэлцжээ. Манай нам, засгаас гадаад бодлогын талаар явуулж байсан ажиллагааны шугам зөв байсныг тэр үед тэмдэглэжээ²⁰. Дэлхийн II дайны дараа Хятад, Зөвлөлт гэдэг хоёрхон улстай дипломат харилцаатай явсан нь томхон ололт байсан бол 1948 онд Хойд Солонгос, 1949 онд Албани нэмэгджээ. Мөн ДИУ-ын халааг авсан БНХАУ манай улсыг зөвшөөрч 4 улстай дипломат харилцаатай болоод байтал 5 жилийн дараа 1954 он гэхэд 12 улс болгож чаджээ. Энэ бол гэнэтийн том дэвшил байлаа. Энэ “арван хэд” гэдэг “тоо”-ны төлөө монголын үе үеийн улс төрчид 40 жил шаналал туулж, хэлмэгдсэн ба тэр үедээ энэхүү “арван хэд” гэдэгт нь гуравдагч хөршөө тоолж тооцож нэрлэсэн хэрэг байсан биз ээ.

МАХН-ын XII их хуралд тавьсан (1954.11.19) илтгэл байна. “Одоо БНМАУ-ын эргэн тойрны бүх хил нь энх тайван, эв найрамдал, харилцан хүндэтгэлийн хил мөн гэдгийг бид асар их сэтгэл хангамжтай тэмдэглэж байна” гээд хоёр хөрш ЗСБНХУ, БНХАУ болон БНАСАУ-тай тогтоосон харилцааг өндөр үнэлээд,

- БНМАУ хүчирхэг ардчилсан лагерийн бүрэлдэхүүний бат хэсэг мөний хувьд Европын ардын ардчилсан орон – БНПАУ, БНЧСУ, БНУАУ, БНБАУ, БНРАУ, БНААУ, БНАГУ-тай дипломат харилцаа тогтоож, ах дүүгийнхээ холбоог байнга бэхжүүлж байна. Тэрчлэн бид БНАВУ-тай дипломат харилцаа

19 БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд аваагүйн үнэн шалтгаан (Улаанбаатар хотын намын идэвхтний хурал дээр тавьсан илтгэл, 1946.10.30), Ю.Цэдэнбал. Илтгэл, үгүүлэл, хэлсэн үг (Гурван боть түүвэр зохиол, I боть, 1941-1954 он), 235 дахь талд

20 МАХН-ын XI их хурал дээр Намын Төв Хорооны ажлын тухай нөхөр Чойбалсангийн тавьсан тайланд гаргасан тогтоол, МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1940-1960 он, II дэвтэр, УБ, 1967, 175-176 дахь талд

тогтоож, харилцаа холбоогоо бэхжүүлж байна²¹ гэжээ.

1950-иад оны дунд үед тийнхүү илтгэж байхдаа ардын ардчилсан гэх социалист орнуудын хүрээнээс хальж өргөн хүрээнд дипломат харилцаатай болох тухай төсөөлж төлөвлөж байгаагүй ч 1956 онд ЗХУКН-ын XX их хурлаас нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших боломжийн тухай ленинч зарчим гэдгийг тунхагласны дараахнаас дипломат харилцаатай орнуудын тооны хойноос хөөцөлдөх практикт манай төр-засаг эргэлтгүй шилжжээ.

5. Социализмын үед гуравдагч хөршийн эрэлд

Тоог нэмэхийн төлөө бүр цөхрөлийн үгс гэж үзэхээр “Хүн төрөлхтөний тэн хагасаас илүү хүн ам бүхий улс оронтой”, “Дөрвөн тивийн төдөн оронтой” дипломат харилцаа тогтоож чадлаа гэсэн мэдэгдлүүд эрх баригч намын их хурлын илтгэлүүддээ оруулж индэр дээрээс бахдалтай уншдаг байжээ. Тэгээд ч тэр ахиулж байгаа “тоо” нь ихээхэн үнэ цэнээр олдсон, тэгж дипломат харилцаа тогтоосноо хөгжил дэвшлийн нэг чухал шалгуур гэж үзэн ёс төртэй зарладаг практик даруй 30 жил хэрэгжин МАХН-ын XIX их хурал (1986 он) хүртэл үргэлжилсэн байдаг юм.

1958.03.17 – МАХН-ын XIII их хуралд нөхөр Д.Дамбын тавьсан тайлангийн “Олон улсын байдал ба БНМАУ-ын гадаад байдал” гэсэн I дүгээр бүлэгт Зөвлөлт Холбоот Улс, БНХАУ, Албани, Болгар, Унгар, Ардчилсан Вьетнам, Ардчилсан Герман, БНАСАУ, Польш, Румын, Чехословак, Югослав зэрэг найрамдалт харилцаатай 12 улсын хөгжил дэвшил, эдгээр улстай тогтоосон харилцаандаа үнэлэлт дүгнэлт өгөөд,

- Янз бүрийн системтэй улсын хоорондын үндэс болсон энх тайвнаар зэрэгцэн орших алдарт таван зарчмыг баримтлан БНЭУ, Бирмийн Холбооны Улс, БНИндонезУ-тай дипломат харилцаа тогтоож, дипломат төлөөлөгчдөө харилцан суулгалаа. Иймд БНМАУ одоо хүн төрөлхтөний тэн хагасаас илүү хүн ам бүхий улс оронтой дипломат харилцаатай болсон

21 Ю.Цэдэнбал. МАХН-ын XII их хурал дээр илтгэсэн МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл, “Намын байгуулалт” сэтгүүл, 1954 оны 12 дугаар сарын № 6

байна. БНМАУ цаашид манай улстай харилцаа тогтоохыг хүсэх бусад улсыг нийгэм, улс төрийн байгууламжийг нь харгалзахгүйгээр энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үүднээс тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх явдлыг үндэс болгож, найрамдалт харилцаа тогтооход бэлхэн байна”²² гэжээ.

Харин энд хэтрүүлэн үнэлсэн, тухайлбал Элчин сайд хавсран томилсноо дипломат төлөөлөгчдөө харилцан суулгалаа гэсэн нь олон улсын харилцааны энэ талын практик урьд өмнө байгаагүйтэй холбоотой. Ийнхүү 1958 онд манай улс нь 15 улстай дипломат харилцаатай болоод байв.

Нийгэм, улс төрийн байгууламжийг харгалзахгүйгээр энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үүднээс дипломат харилцаа тогтоох нь 1960-аад оноос үлэмж өргөжин тэлжээ. 1959 онд НҮБ-аас 1960 оныг “Африкийн жил”²³ хэмээн зарласны дараа тэр онд Гвиней, Камбож, Кубатай, дараа жил нь Балба, Мали, Алжиртай дипломат харилцаа тогтоож, 1961.07.03 онд МАХН-ын их хуралд “Одоо БНМАУ хүн төрөлхтний тэн хагасаас илүүг багтааж байгаа дөрвөн тивийн 21 улстай дипломат харилцаатай байна”²⁴ хэмээн илтгэсэн байна.

1962 он үлэмж ахицтай жил байлаа. Оны эхээр нэг зэрэг Шри Ланк, Афганистан, Ирак, оны дундуур Пакистан, намар нь Лаостой дипломат харилцаа тогтоожээ. Ерөнхий сайд Ю.Цэдэнбалаас 1962.08.19-нд америк, баруун германы хэсэг сэтгүүлчдэд өгсөн ярилцлага чухал баримт болон үлджээ.

- БНМАУ төрийн тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх, бүрэн тэгш эрхтэй байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, олон улсын хоорондын эрхийн зарчмыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхах ямар нэгэн үзэл гаргахгүй байх үндсэн дээр өрнө зүгийн орнуудтай, түүний дотор АНУ, Их Британи улстай

22 Д.Дамба. МАХН-ын Төв Хорооноос намын XIII их хуралд тавьсан тайлан илтгэл, МАХН-ын XIII их хурлын материал, УБ, 1958, 7-12, 18-20 дахь талд

23 “Африкийн жил”-ийг Монголд халуун дотно хүлээн авч Гвиней, Малийн Ерөнхийлөгч нарыг урьж айлчлуулан Гвинейн нийслэлд ЭСЯ-аа нээж ажиллуулж байв – Зохиогч

24 Ю.Цэдэнбал. МАХН-ын Төв Хорооноос намын XIV их хуралд тавьсан тайлан илтгэл, мөн хурлаас гаргасан тогтоол, УБ, 1961, 27 дахь талд

хэвийн харилцаа тогтооход одоо ч гэсэн бэлэн байна²⁵.

- Манай орон нийгмийн байгууллыг үл харгалзан их, бага аль ч улстай найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлж, энх түвшин зэрэгцэн орших зарчмын дагуу хамтран ажиллах энх тайвны бодлого явуулсаар байна²⁶.

Энд дипломат харилцаатай холбоогүйгээр өөр нэг харамсалтай баримтыг оруулъя. БНМАУ НҮБ-д элслээ, одоо тэгэхлээр хөгжлийнхөө программыг биелүүлэхэд НҮБ-аас ямар тусламж хүсэхээр бодож байна гэсэн асуултад “Дэлхийн социалист системийн гаднаас эдийн засгийн тусламж авахгүй байх бололцоотой байна”²⁷ гэсэн байх юм.

1963 он бол Монголын гадаад харилцааны түүхийн шинэ үе эхэлсний бэлгэдлийн жил байсан хэмээн үзэж болно. Энд гуравдагч хөрш хэмээн үздэг хүндэтгэдэг өрнөдийн орнуудтай анх удаа харилцаа тогтоосон тул гуравдагч хөршийн бодлогын нэгэн чухал үе шатны эхлэл хэмээн би нэрлэж байна. Үүнд тэрхүү 1963 онд өрнөдийн гүрнүүдээс Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Австри, Финланд, мөн Египет дипломат харилцаа тогтоосон байдаг ба 1964 онд Швейцарь, Швед, 1965 онд Франц нь манай улсыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоожээ. Энд капиталист ертөнцийн 6 улс, түүний дотор төвийг сахисан 4 улс найрамдлын гараа манайх руу сунгасан байна.

Тэр үед *Reuters* агентлагийн сурвалжлагч Адам Лонг гэгч Ерөнхий сайд Ю.Цэдэнбалтай ярилцсан сурвалжлага-ярилцлагад манай Засгийн газрын тэргүүн ингэж үнэлжээ.

- Манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтсон явдал нийгэм, улс төрийн янз бүрийн байгуулалтай орнууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчим амьдрах чадалтайг гэрчилж байна²⁸.
- НҮБ-ын дүрмийн өндөр зарчмыг хүндэтгэдэг, эрх чөлөө, энх

25 Ю.Цэдэнбал. Илтгэл, үгүүлэл, хэлсэн үг (Гурван боть түүвэр зохиол, III боть, 1961-1956 он), 170 дахь талд

26 Ю.Цэдэнбал. Илтгэл, үгүүлэл, хэлсэн үг (Гурван боть түүвэр зохиол, III боть, 1961-1956 он), 173 дахь талд

27 Мөн тэр ном, 172 дахь талд

28 Мөн тэр ном, 271 дэх талд

тайван, дэвшил хөгжлийг хангахын төлөө бүх улс түмний найрсаг хамтын ажиллагаа, харилцан сайн ойлголцох зарчмыг хүндэтгэдэг НҮБ-ын бусад гишүүн улс оронтой найрамдалт харилцаа тогтооход БНМАУ-ын Засгийн газар бэлхэн байна²⁹.

Ингээд 1966 онд МАХН-ын ээлжит их хурал хуралдах үед дипломат харилцаатай гадаад улсын тоо 30 хол давсан байлаа. Ердөө 10 жилийн тэртээх зун гэхэд Энэтхэгийг оролцуулаад 13 байсныг бодохул тоо, чанарын хойноос нэн идэвхтэй хөөцөлдсөний үр дүн гэж үзэхээр юм.

1966.06.07 – Тайлангийн хугацаанд БНМАУ-ын гадаад харилцаа амжилттай өргөжиж, олон улсын байдал нь бэхжиж, дэлхийн тайзан дээр нэр хүнд нь дээшиллээ. Одоо БНМАУ дөрвөн тивийн 33 улстай дипломат харилцаатай, 20 гаруй оронтой худалдааны харилцаатай байна³⁰ гэжээ.

Энэчлэн цаашаа дипломат харилцаатай улс орныг нэмэх марафон үргэлжилнэ.

1971.06.07 – Тайлангийн хугацаанд БНМАУ нийтдээ 20 гаруй улстай дипломат харилцаа тогтоолоо. Одоо манай орон дэлхийн 53 улстай дипломат харилцаатай болов. Энэ нь социалист Монголын нэр хүнд олон улсын хэмжээн дээр өсч, гадаад харилцаа нь цаашид хэлбэрэлтгүй өргөжиж байгааг гэрчлэн харуулж байна³¹ гэжээ.

1976.06.14 – Ерөнхийдөө 1971-1975 онд БНМАУ-ын гадаад харилцаа нэлээд өргөжлөө. Одоо манай орон дэлхийн 79 улстай албан ёсны дипломат харилцаа тогтоогоод байна³² гэжээ.

1981.05.26 – Манай гадаад бодлогын үйл ажиллагааны дүнг гаргахдаа тайлангийн хугацаанд БНМАУ-ын гадаад харилцаа ихээхэн өргөжиж, олон улсын үйл ажиллагаанд манай улс улам бүр бүтээлтэй оролцох болсныг хэлж болно. Одоо манай орон дэлхийн 91

29 Мөн тэр ном, 272 дахь талд

30 Ю.Цэдэнбал. МАХН-ын XV их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэл, УБ, 1966, 27 дахь талд

31 Ю.Цэдэнбал. МАХН-ын XVI их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл, УБ, 1971, 33 дахь талд

32 Ю.Цэдэнбал. МАХН-ын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл, УБ, 1976, 18 дахь талд

улстай дипломат харилцаатай бөгөөд олон улсын нэр хүндтэй олон байгууллагын гишүүн байгааг тэмдэглэхэд таатай байна³³ гэжээ.

1986.05.28 – Эдүгээ Монгол улс дэлхийн 99 оронтой дипломат харилцаатай бөгөөд олон оронтой улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн болон бусад салбарт идэвхтэй хамтран ажиллаж байгаа нь БНМАУ-ын олон улсын нэр хүнд улам өсөн бэхжиж байгааг гэрчилж байна³⁴ гэжээ.

6. Дипломат харилцаа – гуравдагч хөршийг эрэлхийлэх чармайлтын төгсгөл үе

Ийнхүү БНМАУ-ын үед МАХН ба Ардын засгаас гадаад харилцаагаа бэхжүүлэхийг ихэд чухалчилж байжээ. Дипломат харилцаатай гадаад улсын тоог нэмээд л байвал тэр хэрээр тусгаар тогтнол, олон улсын байр суурь бэхжээд, нэр хүнд өсөөд байна гэж үзээр иржээ. Тэр нь ч худал биш юм. Харин тэгж улс орны тоо зааж намын их хуралдаа илтгэдэг байсан үе социализмтайгаа түүх болсон. МАХН-ын XX их хурал 1991 онд хуралдахад хоёр хөрш орны коммунист намуудтай тогтоосон харилцааг чухалчилж, социалист орнуудын бусад намуудтай хамтран ажиллахыг эрмэлзэнэ, харин гадаад бодлого дээр төр-засгаа дэмжинэ, АНУ-д Ерөнхийлөгчийн хийсэн айлчлал ач холбогдолтой боллоо гэх утгаар гадаад харилцаагаа томъёолж байжээ³⁵.

Ардчиллын жилүүдэд Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон улсын тоо прогрессоор өссөн. 1986 онд 99 орон боллоо хэмээн зарлаж байсан бол шинэ XXI зуун эхлэх үед 144 болоод байв. Түүнээс хойшхи 15 жилд 187 болтлоо өсчээ.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санаа болон Засгийн газрын үйл ажиллагааны удаа дараагийн хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтын

33 Ю.Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт УБ, 1981, 24 дэх талд

34 Нөхөр Ж.Батмөнхийн тавьсан илтгэл, МАХН-ын XIX хурал, дэлгэрэнгүй тайлан, УБ, 1986, 27 дахь талд

35 МАХН-ын XX их хурал (1991.02.25-28), УБ, 1991

хүрээнд НҮБ-ын гишүүн, Монгол Улстай дипломат харилцаагүй улс орнуудтай дипломат харилцаа тогтоох ажлыг хэрэгжүүлэх ажил өнгөрсөн 5 жилд эрчтэй үргэлжилсэн.

Монгол Улс олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх, дэлхийн улс орнуудтай найрсаг харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэх, тэр дундаа гуравдагч хөрш улсуудыг нэмэх зарчмын хүрээнд НҮБ-ын гишүүн бүх оронтой дипломат харилцаа тогтоох чиглэлийг Монгол Улсын өмнөх Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тусгаар тогтнолоо сэргээн тогтоосны 100 жилийн ой тэмдэглэх ажлын хүрээнд 2010 онд өгсний дагуу Монгол Улстай дипломат харилцаагүй 45 улсад (НҮБ-ын гишүүн) 2010.12.30-наас хойш ГХЯ захидал илгээн яриа хэлэлцээ явуулан ажиллаж байжээ.

Тэр тухай өмнөх Ерөнхийлөгч явцыг нь дүгнэж хэлсэн үгс архивт байна:

- Манай улс НҮБ-д элсэн орсны 50 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэв. Бид НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын бусад байгууллага, олон талт механизмын хүрэн дэх хамтын ажиллагааг өргөжүүлэхийн төлөө хүч чармайлт тавин ажиллаж байна. 2011 оны чухал зорилтын нэг бол НҮБ-ын гишүүн бүх улс оронтой дипломат харилцаа тогтоох явдал байсан бөгөөд уг зорилтын хүрээнд бид 12 улстай дипломат харилцаа тогтоохоор хэлэлцэн тохирч, хамтарсан албан мэдээнд гарын үсэг зураад байна³⁶.

Тухайн үеийн Гадаад хэргийн сайд мөн энэ ажлын талаар: НҮБ-д манай улс элссэний хагас зуун жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилт тавьж байна. Эдүгээ манай улс НҮБ-ын гишүүн 150 улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд өшөө 44 оронтой дипломат харилцаа тогтоогоогүй байгаа юм. Нээлттэй гадаад бодлогын хүрээнд эдгээр улстай дипломат харилцаа тогтоосноор манай улсын гадаад харилцаа улам өргөжин тэлж дэлхийн аль ч өнцөг буланд хүрэх болно³⁷ хэмээн мэдэгдэж байв.

36 <http://www.president.mn/mongolian/node/2361>

37 ДТГ-ын тэргүүн нарын зөвлөлгөөн дээр Г.Занданшатар сайдын хэлсэн үг, <http://www.old.mfa.gov.mn/> 2011.03.05

2016 оны байдлаар Монгол Улс 5 шинэ улстай (Габон, Сент Люси, Нигер, Камерун, Маршаллын Арлууд) дипломат харилцаа тогтоож, 187 дахь нь болох Жибүти улстай холбогдох баримт бичигт гарын үсэг зураад байлаа. Ингээд 187 улс болж, цаана нь “193”-аас харилцаагүй улс НҮБ-д 6 үлдэж байна. Энэхүү “187” гэдэг бол үнэндээ гуравдагч хөршийн төлөөх их чармайлтыг илтгэх тоо хэмээн үзэж болно. Учир нь 100 жилийн өмнө ганц ч байгаагүй, 60 жилийн өмнө дөнгөж 10-хан байсан гэж үзвэл харьцуулшгүй том дүн гарч байна.

Монгол Улсад өрнөсөн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйлсийг амжилттай хэрэгжүүлэхэд өрнө, дорнын өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудаас 1990-ээд оны эхнээс үзүүлсэн оюун санааны болон санхүүгийн дэмжлэг онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ. Эдгээр оронтой улс төрийн харилцааны хувьд хүрсэн түвшинг бататгах, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь хөрш хоёр оронтой харилцах харилцаанд тэнцвэржүүлэгч гол хүчин зүйл, манай аюулгүй байдлын нэг чухал баталгаа гэж бид үзэж ирсэн. Тиймдээ ч бид “гуравдагч хөрш”, “стратегийн түнш” гэж нэрлэдэг, энэ ойлголтод аль нэг тодорхой гуравдагч орныг онцлолгүй, бүлэг улс орныг бүхэлд нь хамруулж ойлгож ирсэн.

Тэр утгаараа “Гуравдагч хөрш” гэдэг нь зөвхөн газар зүйн бус, улс төр, эдийн засгийн хүрээг хамарсан ойлголт бөгөөд энэ нь бас Монгол Улсын ардчиллыг тууштай дэмжигч өрнө, дорнын орнуудын бүлэг болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектыг оруулж буй хам ойлголт хэмээн үзэж, тэр үзлээ ч нэгэнтээ хэвшүүлсэн болно.

Ардчилалд шилжээд, гадаад нээлттэй бодлогоо явуулаад 10 гаран жил өнгөрөхөд, XXI зуун эх гэхэд гуравдагч хөршийн бодлогодоо тодорхой ахиц гаргаж чадсан байв. Тухайлбал Монгол-АНУ-ын стратегийн түншлэл ба хамтын ажиллагаа амжилттай өрнөсөн. Япон улстай XXI зууны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцаа, БНСУ-тай “Бие бие нөхсөн харилцаа, хамтын ажиллагаа”-г тогтоогоод амжсан. Монгол-Энэтхэгийн орчин үеийн харилцааг олон зууны соёлын уламжлалт дотно харилцаа бүхий “Оюун санааны хөршүүд” хэмээн хоёр талдаа үздэг болсон. Канадтай өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа хөгжүүлсэн. Европын Холбоотой түншлэлийн гэрээ

байгуулахаар зэхсэн байсан. Монгол-Туркийн “Иж бүрэн түншлэл”-ийн төлөвших шатандаа орсон зэрэг нь энэхүү үзэл санааны тодорхой илэрхийлэл болж байсан³⁸.

Ийнхүү гадаад бодлогын амжилтынхаа нэг үеийг нэгтгэн дүгнэсэн хөх номоо боловсруулж байхдаа бид “гуравдагч хөрш”-ийн үзэл баримтлалаа цаашид гүнзгийрүүлэн боловсруулах, томъёолох, төр засгийн түвшинд нэгдсэн ойлголттой болох нь чухал гэж үзэж байлаа. Учир нь манай оронд тохиож болох нийгмийн тогтворгүй байдал, улс төрийн хямрал, улс төрийн дэглэмийн гэнэтийн өөрчлөлт, мөн байгалийн гамшиг бэрхшээл, далайд гарцгүй байдал зэрэг сөрөг хүчин зүйлийг даван туулахад энэхүү үзэл баримтлал чухал үүрэгтэй гэсэн үндэслэлийг бид гол болгож байлаа.

7. Гуравдагч хөршийг сөрсөн алхмууд

Гуравдагч хөрштэй байх тухай монголчуудын 1990-ээд оны эхний сэдэл хувилбар хоёр хөрш орны эрх баригчдын хардлагыг эхэндээ төдийлөн төрүүлээгүй юм. “Хөрш хоёр орон ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх, аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ”³⁹ гэсэн гадаад бодлогын эн тэргүүний зорилт үндсэндээ амжилттай хэрэгжиж ирсэн. Энэ нь тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үндсэн дээр сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх салбарт идэвхтэй хөгжүүлэхийг хэлсэн хэрэг байв. Нөгөө талаасаа манай хойд хөрш ОХУ, өмнөд хөрш БНХАУ-ын олон улсын жин нөлөө түргэн өөрчлөгдөж, өсч бэхжиж, манай улсын эргэн тойрны геополитикийн болон геоэдийн засгийн орчин байнга хувьсаж ирсэн. Хоёр хөрш гүрний хооронд стратегийн түншлэлийн харилцаа хөгжиж, итгэлцэл нэмэгдэж ирсэн нь Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдалд таатай нөхцөл бүрдүүлсэн, бүрдүүлж ч байна.

38 Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, 11 дэх талд

39 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, <http://www.mfa.gov.mn/>

Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн улс орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны түвшин байнга өсч, Монгол Улсыг дэмжигч, хамтран ажиллагч түншүүдийн тоо улам бүр нэмэгдэхийн хэрээр хоёр хөршийн зүгээс гуравдагч хөрштэй нь хэт зузаан харилцуулахгүй байх гэсэн далд санаа цухалзаж ирсэн болно.

Ялангуяа батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагаа эрс идэвхжиж, өрнө-дорнын өндөр хөгжилтэй орнуудаас Монголд айлчлан ирэх дээд түвшний төлөөлөгчдийн айлчлал тогтмолжин, хоёр урсгалтай болохын хэрээр яваандаа хоёрын хөршийн зүгээс хардах, хариу үйлдэл үзүүлэх, хариу хувилбар хоёр хөршөөс дэвшүүлэхэд хүргэсэн.

Нөгөө талаас ардчилсан зарчим, хүний эрхийг дээдэлдэг зэрэг дотоод хүчин зүйл нь өрнөдийн орнуудтай хэл үгээ ололцоход бэлээхэн хөрс нь болж ирсэн бол хоёр хөрш, юуны өмнө Хятадтай харилцаа хөгжүүлэхэд итгэлцлийн хомсдол⁴⁰ гээч үзэгдэл дагалдсан. Үл итгэх явдал нь хардлага цаашаа өргөжихөд түлхэц болсон. 1996 онд Монголд ардчилсан хүчин анх удаа засгийн эрх авахад энэ бодлого уламж эрчимжиж цаашдын төлөвлөө олсон.

Тэгээд ч 1990-ээд оны сүүлч үе гэхэд гуравдагч хөршөөс нь сэргийлэх, үгүй ядаж гуравдагч хөршийг нь саармагжуулах бодлого руу шилжсэн. Үүнд Монголыг хөршүүдийнх нь хүрээнд уяж торгоох хувилбарууд Москва, Бээжинд боловсрогдож, элдэв саналын хэлбэрээр илэрч эхэлсэн байж болно. Үүнд Монголыг хоёр хөршийн хяналтад уяж торгоох тэрхүү бодит нөхцөлийг хоёр хөрш бодитой олж харсан ба тэр нь:

- Монгол дахь эдийн засгийн уналт доройтол,
- Монголын дэд бүтцийн хөгжилгүй байдал,
- Монголын гадаад өр, төлбөр, санхүүгийн доройтол,
- Монголын үндэсний эв нэгдэлгүй байдал, улс төрийн дотоод тэмцэл,
- Монгол-Зөвлөлтийн найрамдлаа санагалздаг сэтгэхүй,
- Монголын “нэг цонх”-ны бодлогын гажуудал,

40 Итгэлцлийн хомсдолтой харилцаа, <https://www.news.mn/content/print/186512>

- Гадаад түншдээ олзлогддог монголчуудын сул тал,
- Монголчуудын санхүүгийн сахилга батгүй байдал зэргийг нэрлэж болно.

Эдгээр сул талуудыг олж харж, түүндээ дөрөөлөн Монголыг хоёр хөршийн хяналт, тулгалтад оруулах бодлого руугаа шинэ зууны эхнээс шилжиж орсон. Жишээ нь Ерөнхийлөгч Х.Баттулгын олж харж, онож хэлснээр, “1990 он хүртэл манай урд хил хаалттай, зөвхөн хойшоо харж хойд хөрштэйгөө харилцдаг байлаа. Гэтэл өнгөрсөн 27 жилийн хугацаанд хойд хөрштэйгээ бараг эдийн засгийн харилцаагүй болчихсон. Урагшаагаа хэт хэлбийчихсэн байна”⁴¹ гэсэн нь чухамдаа Монголын эдийн засгийн сул тал нь өөрөө ингэж хэт хэлбийлгэх үндсэн болсон, үүнд нь ч өмнөд хөрш идэвхтэй ажилласан гэсэн санаа юм.

Гурван тал, гурвалсан хамтын ажиллагааны тухай саналууд 2000-2004 онд Н.Энхбаярын Засгийн газрын үеэр түлхүү тавигдсан. Харин хожмоо Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж гурван улсын Төрийн тэргүүний уулзалтын механизм санаачлан хэрэгжүүлэх тухайд ХХI зууны эхээр төсөөлж төлөвлөж байсан нь үгүй. Яг үнэндээ одоогийн “Эдийн засгийн коридор”-ын тухай энэ төсөөллийг ХХI зууны эхээр Н.Энхбаярыг Ерөнхий сайд байх ахуйд бидэнд санал болгож байсан.

Үнэндээ 2000-2004 оны үед Монголын гадаад харилцааны түвшин, олон нийтийн санаа бодол, ялангуяа ГХЯ-ны бодлого боловсруулагчдын (би өөрөө нэг нь байсан) хувьд хоёр хөрштэй ямар нэгэн хэлбэрээр гурвалсан харилцаанд орох нь гуравдагч хөршийн бодлогоосоо салах нэг хэлбэр хэмээн үзэж болгоомжлох, татгалзах хандлагатай байсныг ГХЯ-ны Гадаад харилцааны төв архивт хадгалагдаж буй бодлогын баримт бичгийн дараахи дүгнэлт нотолно. Үүнд:

1. Ийм механизм байх нь хэрэгтэй.
2. Аль аль орны эрх ашгийг зэрэг хөндсөн байх шаардлагатай.
3. Ийм асуудлын тоонд гурван талын эдийн засгийн хамтын

41 Л.Пүрэвсүрэн: Орос, Хятадтай сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ,

<http://www.president.mn/content/12596>

ажиллагаа /дамжин өнгөрөх тээвэр, нефть, хий дамжуулах хоолой, өндөр хүчдлийн шугам, мөн байгалийн гамшигтэй тэмцэх, хил дамжсан түймэр, цөлжилт, үер ус, хүн, малын гоц халдварт өвчин ДОХ, шүлхий г.м./

4. Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар ийм гурван талын механизм байх нь Монгол Улсын эрх ашигт нийцэхгүй. Энэ талаархи байр сууриа Орос, Хятадын талд сайтар ойлгуулах ёстой. Үндсэн хууль, Гадаад бодлогын үзэл баримтлалаа иш үндэс болгож байгаагаа мэдэгдэх. Энэ нь Монгол Улс бие даасан, үндэсний эрх ашгаа дээдэлсэн гадаад бодлого явуулж байгаагийн үндэс болно.
5. Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөж болох олон механизм байгаа. Үүнд НҮБ, АРФ, хоёр талын зөвлөлдөөнүүд г.м.
6. Гурван улсын хилийн уулзварын асуудлаар 3 талын яриа хэлэлцээнд оролцох нь зүй. Харин хил дэглэмийн болон иргэд хоорондын, консулын зэрэг асуудлаар хоёр хөрштэй тус тусад нь харилцаж ирсэн уламжлалыг баримтлах саналтай⁴².

XXI зууны эхэн үеийн, тэгэхдээ би өөрөө биеэр байлцсан үйл явдлын хоёр баримтыг энд дурдах нь зүйтэй мэт. Хэвлэлд ил тавигдаагүй тул шинэлэг байж болно. “Монгол, Хятад, Орос улсуудын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизм бий болгох, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад Монгол Улсыг нэгдэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлаар санал солилцож, тохиролцоонд хүрч чадлаа” хэмээн тухайн үеийн БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Тан Цзясюань Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид хэлж байсан баримт байна. Миний бие Монгол-Оросын ГХЯ-дын газрын захирлуудын түвшний яриа хэлэлцээнд оролцох завшаан тохиож байсны хувьд гурвалсан яриа хэлэлцээнд ОХУ-ын зүгээс уриалан дуудаж, ятгаж байсныг тэмдэглэж үлдээжээ. 2001 оны 12 дугаар сард ГХЯ-нд болсон санал солилцох уулзалт дээр ОХУ-ын ГХЯ-ны Азийн нэгдүгээр департаментын

⁴² Орос-Монгол-Хятадын гурван талын механизмын тухай, ГХЯ-ны БТМҮГ-ын зөвлөмжийн төсөл, Гадаад харилцааны архив, 2002 оны 2 дугаар сар (Боловеруулсан Д.Баярхүү)

захирал Е.В.Афанасьев яг ингэж ярьсан тэмдэглэл нь надад байна⁴³.

ШХАБ байгуулагдсан цагаас түүн рүү ил далд, элдэв хэлбэрээр Монголыг шахсан. Евразийн Эдийн засгийн холбоо –Гаалийн холбоог шууд бус хэлбэрээр санал болгож байна. Улмаар Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны форумыг өмнөд хөрш нь санал болголоо. Умард хөрш нь Байгалийн эдийн засгийн форум, Дорнын эдийн засгийн форум, “Сибирийн хэлэлцээр” бүс хоорондын нийгэмлэгтээ аажмаар татан орууллаа.

8. ШХАБ

“Шанхайн тав” буюу Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) нь анх ОХУ, Хятад, Казахстан, Кыргызстан, Тажикистаны хоорондын хилийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үүссэн. Тухайн үед ШХАБ руу уриалах шахах байдал ажиглагдаж байх үед ГХЯ-наас дараахи санал зөвлөмжийг бэлтгэн Төрийн гурван өндөрлөг рүү хүргүүлж байжээ. Үүнд:

“Шанхайн тав”-д ордог 6 улс – Казахстан, БНХАУ, Киргиз, ОХУ, Тажикстан, Узбекистаны төрийн тэргүүн нар энэ оны 6 дугаар сард Шанхай хотноо хуралдаж Хамтын ажиллагааны Шанхайн байгууллага байгуулсанаа зарлав. Дээрхи уулзалтаас Тунхаглал гаргажээ. Монгол Улс уг байгууллагад нэгдэн орох эсэх асуудлыг юуны өмнө Монголын үндэсний эрх ашгийн үүднээс авч үзэх нь зүйтэй байна. Энэ үүднээс авч үзвэл одоогоор Монгол Улс уг байгууллагад элсэн орох шаардлага байхгүй байна. Ийм дүгнэлтийг дараахи хэдэн үндэслэлд тулгуурлан хийж байна. Үүнд:

- “Шанхайн тав” бол анхнаасаа эдгээр орнуудын хоорондын хилийн маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгоор үүссэн бөгөөд харин Монгол Улс хөрш хоёр оронтой хил хязгаарын ямар нэг маргаангүй, энэ асуудал бүрэн хэмжээгээрээ шийдвэрлэгдсэн. Иймд “Шанхайн тав”-ын үндсэн зорилго Монгол Улсад хамаарахгүй юм.

⁴³ Зохиогчийн хувийн архив; Монголын геополитикийн төсөөлөл, “Засгийн газрын мэдээ”, 2017.08.04 № 145 (691)

- Дээр дурдсан Тунхаглалд зааснаас үзвэл Хамтын ажиллагааны Шанхайн байгууллагын үндсэн зорилгуудын нэг болох - терроризм, салан тусгаарлах ба хэт даврах үзэл, зэвсэг, хар тамхины хууль бус наймаа, дүрвэгсдийн миграцийн асуудал зэрэг нь Монгол Улсад өнөөгийн нөхцөлд Монгол Улсад байхгүй, иймд эдгээр асуудлаар гишүүн улсуудтай харилцах бодит үндэс байхгүй.
- Тунхаглалын 9 дүгээр зүйлд заасан худалдаа-эдийн засаг, хөрөнгө оруулалттай холбогдсон заалтуудыг үндсэндээ хоёр талын шугамаар хэрэгжүүлж болох бөгөөд харин манай эрх ашигт нийцэхүйц нефть, хийн хоолойн төслүүдийг нэгэнтээ Монголыг тойруулан хэрэгжүүлэхээр шийдсэн учир Монгол Улс эдийн засгийн ашиг тооцож уг байгууллагад нэгдэх нь ч манайд бас ашиггүй болж байна.
- Тунхаглалын 4 дүгээр заалтад гишүүн орнууд бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны асуудлар нягт зөвлөлдөн хамтран ажиллах, олон улсын стратегийн тэнцвэр, тогтвортой байдлын тухай заасан байна. Энэ нь гишүүн орнууд, ялангуяа ОХУ, БНХАУ —ын зүгээс бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар манай улсад /тухайлбал, ПРО г.м./ даралт шахалт үзүүлэх магадлалтай.
- Тунхаглалын 5 дугаар зүйлд заасанчлан энэ байгууллагын гишүүн орнууд дээд хэмжээний уулзалтын сацуу яамд, шинжээчдийн түвшинд элдэв уулзалт зөвлөлдөөн зохион байгуулах бөгөөд иймэрхүү олон шатлалт, хүн суртлын механизмд оролцох бодит бололцоо, шаардлага манай улсад байхгүй юм.
- Нөгөөтэйгүүр уг байгууллагын олон уулзалт зөвлөлдөөнд оролцох, үндэсний зохицуулагч, түүний аппаратыг томилж ажиллуулах тийм зардал, төсөв Монгол Улсад өнөөдөр алга байгааг бодолцох ёстой.
- Төв Азийн орнуудтай Монгол Улс шууд хиллэдэггүй, хоёр талын идэвхтэй харилцаа гэхээр юм байхгүй байгааг ч мөн давхар тооцоолох нь зүйтэй юм.

- Цаашилбал дээр дурдсан Тунхаглалд заасанчлан, Хамтын ажиллагааны Шанхайн байгууллагын зорилго, зарчим, хэлэлцэх асуудал зэргийг тусгасан Шанхайн Харти гэдгийг хэтдээ байгуулах бөгөөд чухам ямар баримт бичиг гарах нь тодорхойгүй, ерөнхийдээ энэ байгууллага дүр төрхөө олоогүй, эхлэлийн шатандаа яваа гэдгийг бодолцох хэрэгтэй. Уг байгууллагын гол хоёр гишүүн – ОХУ, БНХАУ – ын албаны хүмүүс хоорондоо зөрчилтэй мэдэгдэл хийсээр ирсэн нь үүнийг нотолж байна.
- Монгол Улсын гол хандивлагч орнууд тухайлбал, АНУ, Европын Холбоо, Япон нь “Шанхайн тав”-ын талаар эргэлзсэн, тандсан байр суурьтай байгааг мөн бодох хэрэгтэй. Ийм нөхцөлд хэрэв энэ байгууллагыг Монгол Улс хэт сонирхосон байр сууриа илээр илэрхийлбэл бидэнд сөрөг үр дагавар авчирч болзошгүй⁴⁴.

Ер нь ШХАБ-д гишүүнээр элсүүлэхийг Оросын зүгээс шахсан, уриалсан, лоббидсон түүх ганц Монгол гэлтгүй бусад улсууд дээр харагддаг. 2001 оны нэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Энэтхэгт төрийн айлчлал хийхэд (би тэр үед Дели дэх ЭСЯ-нд Зөвлөх байсан) “Танай улс тэр “Шанхайн тав”-даа нэгдэж орж болдоггүй юм уу, яагаад болохгүй гэж” хэмээн Монголын Төрийн тэргүүнтэй хэлэлцээ хийсэн БНЭУ-ын Ерөнхий сайд А.Б.Важпаи шууд хэлж байсан. Өмнөхөн нь ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Энэтхэгт айлчлаад Важпаитай хэлэлцээ хийгээд буцсан, энэ бол Путины дайсан үг болов уу⁴⁵.

ШХАБ нь улмаар улс төр, аюулгүй байдлын асуудлын сацуу худалдаа-эдийн засаг, бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлуудыг хамруулан авч үзэх хандлагатай болж байгаа нь Монгол Улсын сонирхлыг зүй ёсоор татаж ирсэн ба ажиглагчаар элсэх бодит нөхцөл болж шат ахисан билээ.

Тус байгууллагын төлөвшилт, олон талт үйл ажиллагааных нь

⁴⁴ Хамтын ажиллагааны Шанхайн байгууллагад нэгдэн орох эсэх асуудлын тухай. ГХЯ-ны БТМҮГ-ын зөвлөмжийн төсөл, Гадаад харилцааны архив, 2001 оны 8 дугаар сарын 13

⁴⁵ «Шанхай»-г улс төр-стратегийн эвсэл байлгахын төлөөх Орос, “Засгийн газрын мэдээ”, 2017.06.23 № 120 (666);

хандлага тодрохын хэрээр манай талын байр суурь хувьсаж ирсэн бөгөөд анх 2004 онд Гадаад хэргийн сайд ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад (Бээжин) зочноор, мөн онд Ташкентын дээд хэмжээний уулзалтад Ерөнхийлөгчийн бие төлөөлөгчөөр оролцсон юм. Ташкентын уулзалтаас Монгол Улсад ажиглагчийн статус олгосон шийдвэр гаргажээ. 2005 онд Ерөнхийлөгч Н.Энхбаяр Астана хотноо ШХАБ-ын дээд хэмжээний уулзалт, Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Москва хотноо ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцсоноор дээд түвшинд оролцдог уламжлал хэвшин тогтжээ⁴⁶.

Бүс нутгийн хамтын ажиллагаанд улам бүр жинтэй байр суурь эзлэх болж буй энэ байгууллагын үйл ажиллагаанд манай улс зохих ач холбогдол өгч байгаагаар илтгэн ШХАБ-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Жан Дэгуаныг Монголд айлчлуулахаар урьж байсан.

Дээд түвшний уулзалтуудад Монгол Улсын Ерөнхийлөгч оролцдог уламжлал хэвшихийн сацуу 2014 оноос ОХУ нь олон улсын санкцад орж, өрнөдийн улс орнуудтай харилцаа хүйтэрсний хэрээр Монголыг гишүүнээр жинхлүүлэх шаардлага тогтмол цухалзах болсон. Жишээ нь 2014 оны 6 дугаар сард ОХУ-ын ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Н.П.Патрушев Монголд айлчлахдаа тэр оны зуны адаг сард тэмдэглэхээр бэлтгэж байсан Халхын голын дайны ялалтын 75 жилийн ойд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путиныг оролцуулах нөхцөл болгож “ШХАБ-д элсвэл айлчлуулна” хэмээн хэлж байсан баримт үлджээ⁴⁷.

“ШХАБ-д Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ байгууллагад элссэнээр Оросын, эсвэл Хятадын нөлөөнд орно гэж үздэг улстөрчид танайд бийг би мэднэ. Энэ бол огтхон ч тийм биш. Харин ч танай улсад илүү ашигтай байх болно. Газар зүйн байрлал, эдийн засгийн нөхцөл байдал гээд аль ч талаараа Монгол Улс энэ байгууллагын бүрэн эрхт гишүүн байх боломжтой”⁴⁸

46 Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, 66 дахь талд

47 Монгол Улсын ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргаас ярьсан аман түүх, зохиогчийн хувийн архив

48 Төрийн Думын болон Холбооны зөвлөлийн дарга нартай уулзлаа, <http://parliament.mn/news/2016.12.17>

хэмээн ОХУ-ын Төрийн Думын Холбооны Зөвлөлийн дарга нь 2016 онд УИХ-ын дарга М.Энхболдод хэлсэн шинэхэн баримт байна.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн ШХАБ-ыг хариуцсан тусгай төлөөлөгч Бахтиер Хакимовын мэдэгдэл-уриалга шинээр цууриатлаа. “Элсэх цаг нь аль хэдийнэ болсон юм биш үү?” гэсэн ятгалга ч давхар явж байна. Тэрээр:

- ШХАБ Монгол Улсыг дуртайяа гишүүнээр элсүүлэх болно. Гэхдээ Улаанбаатар хараахан албан ёсны хүсэлт гаргаагүй байна.
- Монгол бол ШХАБ-д элсэх бүрэн боломжтой улсуудын нэг. Тус улс нь 2005 онд ШХАБ-ын ажиглагчийн статусыг авсан анхны орон юм. Гэхдээ Улаанбаатар ШХАБ-тай харилцаагаа бэхжүүлэх хүсэл, сонирхолтой байгаа хэдий ч энэ байгууллагад элсэх хүсэлт албан ёсоор гаргаагүй байна⁴⁹ гэжээ.

ШХАБ-д элсэх эсэх дээр албан ёсны хариуг хамгийн сүүлчийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгч ШХАБ-ын 2017 оны Астанагийн өргөтгөсөн саммит дээр маш тодорхой байр сууриа илэрхийлж хэлжээ. Үүнд:

- Манай улс ШХАБ-ын өргөжин тэлэх үйл явц, хөгжил дэвшил, цаашдын төлөв байдлыг анхааралтай ажиглан харж байна.
- Гишүүн болон ажиглагч орнуудын хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулж, хамтын ажиллагааг эдийн засгийн бодит агуулгаар баяжуулах нь чухал юм.
- Монгол Улс гадаад бодлогын залгамж чанараа тууштай хадгалж, олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан гадаад бодлогоо идэвхтэй хэрэгжүүлж ирлээ.
- ШХАБ үйл ажиллагааны хувьд ч өргөжиж, аюулгүй байдал, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар зэрэг олон талт хамтын ажиллагааг хамарсан байнгын ажиллагаатай олон улсын байгууллага болж өсч өндийж буйд баяртай байна.

49 Б.Хакимов: ШХАБ Монголыг дуртайяа гишүүнээр элсүүлнэ, Эх сурвалж: Монцамэ агентлаг, <http://sonin.mn/news/politics-economy/82725>

- Манай улс ШХАБ-тай терроризм, хар тамхины хууль бус наймаатай тэмцэх чиглэлд хамтран ажиллахыг мөн сонирхож байна. Мансууруулах бодистой тэмцэх ШХАБ-ын стратегийг энэхүү хуралдаанаар хэлэлцэн баталсныг бид сайшаан дэмжиж байна. ШХАБ-ын үйл ажиллагаанд оролцогч улс орнуудын хувьд үйл ажиллагаагаа бэхжүүлж, харилцан уялдаа холбоогоо сайжруулах нь Монгол Улсын хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой төдийгүй, дэлхий нийтийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна⁵⁰ гэжээ.

9. Хятадын байр суурь

Хятадын байр суурийг ойлгох оршил болгож Хятадыг сайн судалсан Элчин сайд нэг нөхрөөсөө эшлэе. Тэр ингэж бичжээ.

- Итгэлцлийн хомсдолоос үүдэж Монгол, Хятадын эдийн засгийн харилцаа “цомирлог”-оо гүйцэд дэлгэж чадаагүй явсаар ирснийг үгүйсгэх аргагүй. Төмөр замын нарийн, бүдүүн царигийн асуудал үл итгэх сэтгэхүйгээс үүсэлтэй гэж дийлэнхи эрдэмтэн мэргэд үздэг аж.
- Хөршөөсөө эмээх, болгоомжлох, өөрийгөө хамгаалах сэтгэхүй нь түүхээс улбаалж ирсэн учир шалтгаантай. Гэвч “цаг цагаараа, цахилдаг хөхөөрөө байдаггүй” нь бас үнэн учраас шинэлэг хандлага зүй ёсоор шаардагдаж байна. Дэлхий ертөнц хавтгайрч, даяаршиж, манай эдийн засаг түүнд татагдан орж буй энэ цаг үед улс хоорондын, нэн ялангуяа, хөрш хоорондын харилцаанд бүтээлч сэтгэхүйгээр хандахыг манай улсын хөгжил дэвшлийн үйл явц шаардаж байна.
- Дэлхийн хоёр дахь том эдийн засагтай БНХАУ нь өнөөдөр далай тэнгисийн гүн, сансар огторгуйн алсыг эзэмшиж, удахгүй саран дээр хятад нисгэгчтэй хөлөг буулгахаар шамдаж байна. Хятадын төр, засгийн 5 дахь үеийн шинэ залуу удирдлага олон улсын харилцаа, түүний дэг журамд Хятадын

энх тайванч хөгжил, сэргэн мандалтын оруулах хувь нэмрийг прагматикаар харж, “Хятадын мөрөөдөл”-г хэрэгжүүлэх тааламжтай гадаад нөхцөлийг бүрдүүлэхэд чухалчлан анхаарч байна⁵¹.

Энд юу хэлэх гэж байна вэ? Хятад нь Орос шиг ШХАБ руу Монголыг улайм цайм ил шахахгүй, адгахгүй, уриалахгүй. ШХАБ-ын гишүүн Монгол байсан байгаагүй Хятадад төдийлөн ач холбогдолтой биш гэсэн санаа юм.

Хятадын тухайд байр сууриа ил гаргаж тулгах муйхар байдал үзүүлэхгүй боловч Монгол-АНУ-ын, Монгол-Японы харилцааг ямагт хардаж, тэр хардлагаасаа ямар нэг “эрх ашиг”, “далд хуйвалдаан” олж илрүүлэхийг шууд бусаар зорьж ирсэн. Жишээ нь Монгол-АНУ-Японы хооронд ГХЯ-дын хооронд болдог гурван талт уулзалтын механизм тэгж хардах нэг сэдэв болж байна. Энэ талаар тэдний талын тавьсан асуултад би тодорхой хариу өгч байсан⁵². Монгол-Хятадын харилцаа, Монгол дахь Хятадын эсрэг үзэл бодолд Монгол-АНУ-ын, Монгол-Японы харилцаа тусах вий гэдэг хардлага Монголын талаархи Хятадын бодлогоос нэг хэсэгтээ арилахгүй байх магадлалтай. Хэрэв АНУ ба Японтой харилцахад Хятад гадаад бодлогод саад бэрхшээл учирч байх аваас тэгж хардах хөрс нь Монгол-Хятадын харилцаанд бэлээхэн буй.

Ингэж хардахын сацуу Бээжингийнхэн албан ёсны байр сууриа эвтэй хэлбэрээр, монголчуудад таагүй сэтгэгдэл төрүүлэхгүйгээр тавьж ирсэн. Тухайлбал 2014 онд БНХАУ-ын удирдагч Си Жиньпин айлчлахдаа “Хятад, Монголын найрсаг харилцааны гэрээний дагуу Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн бүтэн байдал, халдашгүй байдал, өөрийнх нь сонгосон хөгжлийн замыг бид хүндэтгэнэ. Бидний урт удаан хугацаанд барих үндсэн бодлого тэр байх болно. Хятад, Монголын харилцаа өндөр төвшинд хүрснийг баяртайгаар тэмдэглэн хэлье. Олон улсын харилцаанд ямар ч өөрчлөлт гарсан гэлээ бидний стратегийн түншлэлийн харилцаа хадгалагдсаар байх

⁵⁰ Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөгтөсөн хуралдаанд үг хэлэв, <http://www.president.mn/content/12443>

⁵¹ Г.Батсүх. Итгэлцлийн хомсдолтой харилцаа, <https://www.news.mn/content/print/186512>

⁵² Монгол Улсын 5 дахь Ерөнхийлөгч Х.Баттулгын гадаад бодлогод баримтлах чиглэлийн онцлог, Монгол-Хятадын хамтарсан эрдмийн хурал, Хөх-хот, 2017.09.26–хурлын үеэр болсон уулзалтууд

болно”⁵³ гэж мэдэгдэж байв. Энд “өөрийнх нь сонгосон хөгжлийн замыг хүндэтгэнэ” гэсэн боловч яг Монгол-АНУ-ын, Монгол-Японы харилцаан дээр эмзэглэдэг хэвээрээ байгаа.

БНХАУ-ын удирдагч Си Жиньпин дэлхий дахин руу хандуулж хэлэхдээ: Хятадын ард түмэн дэлхийн улс түмнүүдийг Хятад улсын хөгжлийн “хурдан галт тэрэг”, “аяны галт тэрэг”-нд суухыг гар дэлгэн урьж байна. Харилцан хамтарч, нэгдэж ажиллах явдлыг эрхэмлэн, нээлттэй, хамтдаа хожих хамтын ажиллагааны загварыг буй болгох ёстой. Хүн төрөлхтөн “би байваас та байна, та байваас би байна” гэсэн хувь заяаны цогц нэгдэл. Хятад улс өөрийн улсыг хөгжүүлэхийн зэрэгцээ бусад улс орон, ард түмэнд илүү их ач тусыг хүртээж байна. Хятад улсын хөгжил бол дэлхийн боломж бөгөөд Хятад улс нь эдийн засгийн даяаршлаас үр ашиг хүртэгчээс илүүтэй хувь нэмэр оруулагч мөн⁵⁴ гэхчлэн Давосын 2017 оны чуулга уулзалт дээр ярьсан нь гуравдагч хөршийн талаархи манай байр суурьтай хэр авцалдахыг цаашид судлан үзүүштэй.

Ерөнхийлөгч Х.Баттулгын олж харж, онож хэлснээр, “1990 он хүртэл манай урд хил хаалттай, зөвхөн хойшоо харж хойд хөрштэйгөө харилцдаг байлаа. Гэтэл өнгөрсөн 27 жилийн хугацаанд хойд хөрштэйгээ бараг эдийн засгийн харилцаагүй болчихсон. Урагшаагаа хэт хэлбийчихсэн байна”⁵⁵ гэсэн нь чухамдаа Монголыг гуравдагч хөрштэй нь золгуулах уу, байх уу гэдгийг шийдэх эдийн засгийн давуу эрх Хятадад бэлээхэн байна гэсэнтэй адил шахуу юм. Тиймээс ШХАБ мэт бүс нутгийн хамтын ажиллагааны институц руу заавал шахах гэж асуудал хурцаар тавигдахгүй болов уу.

Монголын нийт экспортын 85%-ийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг: зэсийн баяжмал 45%, чулуун нүүрс 15%, газрын тос 10%-ийг тус тус бүрдүүлдэг бөгөөд зөвхөн Хятадад гарч байна. Монголын гадаад худалдаанд тэнцвэр алдагдсан байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс зөвхөн Оюутолгойн хөрөнгө

оруулалтыг (30.2%) хасч тооцвол Хятадын хөрөнгө оруулалт 40% болно. Ийм нөхцөлд Монгол Улсын хувьд гадаад харилцаагаа тэнцвэржүүлэх нь тулгамдсан зорилт болж байна. Энэ нь харилцааг Хятад, Оростой болон гуравдагч хөршийн орнуудтай тэнцвэржүүлэх, гадаад зах зээлийг өргөтгөх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрш орнуудтай дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохицуулах гэх мэт олон чухал зорилтыг дагуулж байгаа⁵⁶ хэмээн миний Элчин сайд нэг нөхөр маань бичсэнийг онцлон тэмдэглүүштэй.

БНХАУ-ын “Бүс ба зам”, Торгоны замын эдийн засгийн санаачилга зэрэг дэд бүтцийн хамтын ажиллагаанд “гуравдагч хөрш”-ийн хөрөнгө оруулалт, технологийг нэвтрүүлэх боломж Монголд бэлээхэн бүрдэхээр байна. Үүнд монголчуудын идэвхи, санаачилга, хэлсэндээ хүрэх, ажилдаа үнэнч байх чанар гол нөлөө болно. Хятадаас Лондон хүрэх төмөр зам, ОХУ-аас авч буй хийн хоолойгоо Хятад манайхыг тойруулаад явуулж байна. Үнэхээр манай улс орхигдоод байгаа нь ажиглагдаж байна. Өмнө нь Европ-Азийг холбосон гол төмөр зам болох Сибирийн төмөр зам Монгол, Манжуураар л дайрч байсан. Гэтэл одоо нөхцөл байдал өөр болж, өөр гарц, коридор гарч ирлээ. Бид үүнд дүгнэлт хийж, урьдын адил идэвхтэй оролцогч байхыг зорих хэрэгтэй. Тиймээс Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридор байгуулах ажлыг “Бүс ба зам”-тай холбохоос өөр гарц харагдахгүй байна. Эдийн засгийн коридорын хүрээнд 32 төслийг хэрэгжүүлэх боломжтой хэмээн үзэж тодорхойлсон. Голдуу Монголын нутгаар дайраад Орос Хятадыг холбосон дэд бүтцийн төслүүд нь гуравдагч хөршийн хөрөнгө оруулалт, оролцоо, сонирхлыг татсан байхаар ажиллах хэрэгтэй юм.

Гэхдээ Хятадын бодлогод Монгол Улс эдийн засгийн ямар ач холбогдолтой байна вэ, Монголын түүхий эд ба эдийн засгийн өсөлтөөр Хятад дутагдах уу гэдэг асуулт хариултгүй үлдэж болохгүй юм.

Манай уул уурхай түшсэн эдийн засаг, түүний зарим өсөлт 2011-2012 оны үед Монголын улс төрчдийг хөөргөж, Хятадгүй хөгжиж болох мэт гэнэн ойлголт суулгаж, олон түншийг өрсөлдүүлж, уралдуулж,

53 Си Жиньпин: Монголын өөрийнх нь сонгосон хөгжлийн замыг бид хүндэтгэнэ, <https://www.news.mn/r/187480>

54 Дэлхий ертөнц юу болоод байна, Бид юу хийх ёстой вэ? Давосын чуулга уулзалтад БНХАУ-ын Төрийн тэргүүний хэлсэн үг, <http://bayarkhuu.niitlech.mn/content/8354.shtml>

55 Л.Пүрэвсүрэн: Орос, Хятадтай сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ, <http://www.president.mn/content/12596>

56 О.Очиржав. Монгол, Хятад, Оросын гурван талын харилцаа, Монгол-Хятадын хамтарсан эрдмийн хурал, Хөх-хот, 2017.09.26

дундаас нь ашиг олох юм шиг болчимгүй алхам руу түлхэж, хөршөө эгдүүцүүлж, дургүйг нь хүргэж байсандаа монголчууд дүгнэлт хийх хэрэгтэй.

Монголын түүхий нүүрс, зэс, ашигт малтмал, ноос ноолуур БНХАУ-ын ямар салбарт, хаана хэрэгцээтэй, тэр нь хэнд юунд зориулагдсан, худалдаа нь тогтвортой байх эсэх дээр манайханд стратегийн тоймтой судалгаа дутагдалтай байгаа. Хятадын умард ба зүүн хойд хил залгаа муж, Өвөр Монголын аймгуудыг ч бид дутуу судалсан буюу наймаа арилжаа, бизнесээ урсгалаар зөнгөөрөө явуулж ирсэн нь манай талын сул тал юм. Жишээ нь Өвөр Монголын Ордос хэмээх нутаг нүүрс, байгалийн ховор шороо, ховор метал, метаны хий, занарын хүдрээр баялаг, тэнд нүүрс-химийн өндөр технологи бүхий олон арван үйлдвэр уурхай ажиллаж, Монголын түүхий эдээр дутагдах гачигдахгүй байгааг биеээрээ үзэж туулсан хүний хувьд хэлэхэд Монголын түүхий эд, ашигт малтмал дээр Хятадын онцгой ашиг сонирхол гэж төдийлөн байхгүй болов уу хэмээн үзэж байна.

Монголтой хил залгаа Хятадын мужуудын эдийн засгийн ашиг сонирхол гэж Монголын хувьд ч төдийлөн байхгүй болов уу. Тийм учраас “Бүс ба зам” төслийг уухайлан дэмжиж, түүний сүлжээнд манай эдийн засгийг холбох, тэр хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулж оруулах, тийм хөрөнгө оруулалтаас юуны өмнө хоёр хөрш улс ашиг хүртэх боломжийг нь бүрдүүлэх чиглэлээр бодлогоо явуулах нь манай улсын ашиг сонирхолд нийцнэ. Хоёрлосон, гурвалсан, мөн гуравдагч хөрш хэд хэдэн улсын хөрөнгө оруулсан эдийн засгийн солонгорсон төсөл, хөтөлбөр илүү чухлаар тавигдах биз ээ.

10. Гуравдагч хөрш чухлыг ямагт илтгэж байх

“Эдийн засгийн коридор”, “Нэг бүс ба нэг зам” төслүүд Монголд чухал нь мэдээж. Манай эдийн засгийн хөгжил цэцэглэлтэд шууд нэмэх оноо авчирна. Харин хасах оноо юу байх вэ гэдгийг зөв олж харах нь чухал юм. Хоёр хөршөөсөө эдийн засаг-санхүү, дэд бүтцийн хувьд хэт хамааралтай байх нь хасах оноо болох магадлалтай.

Үүнийг сөрөхгүйгээр саармагжуулах хувилбар бол өрнөдийн том орнуудаас том хөрөнгө оруулж ирж нутагтаа шингээх нь манай

эдийн засгийг аюулгүй байдлын нэг том баталгаа, улмаар хөгжил дэвшлийн гол нөхцөл болно. Хэрэв гуравдагч гэгдэх өрнө-дорнын том улс орнуудаас Монголд эдийн засгийн ашиг сонирхлоо суулгаж чадвал тэд Монголыг өөрийг нь биш юм аа гэхэд Монголд оруулсан хөрөнгөө тэд хамгаалах магадлалтай. Энэ тухай Гадаад бодлогын, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхой заасан нь бий⁵⁷. Тэр тухайгаа л бид “гуравдагч хөршийн бодлого” хэмээн томъёолон ойлгож, хэрэгжүүлсээр хэрэгтэй.

Оюутолгойн бүтээн байгуулалт бол гуравдагч хөршийн томхон хөрөнгө оруулалт байж болно. Учир нь энэ төслийн хөрөнгө оруулалт нь хоёр хөршийн нийлбэр хөрөнгө оруулалтаас 2 дахин их гэсэн тооцоо гарч байна. Тэр хэмжээгээрээ Монголыг хоёр хөршийн хүрээнд гарган өгч, цаана нь байгаа дэлхийтэй холбон уяж өгч, өөрөөр хэлбэл нэлээд өргөн хүрээний зах зээлийн тоглогч болгож мэдэх юм⁵⁸.

Оюутолгой мэтийн томхон бүтээн байгуулалтыг гацааж зогсоохсон гэсэн хүсэл хоёр хөршөөс ил далд, нууц хэлбэрээр цухалздаг. Оросын байр суурийг олж харах, мэдрэх боломж бий. Харин Хятадын байр суурь далд бөгөөд аажуу холуур даялаж байх магадлалтай. ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штаб, түүний сургалт-төлөвлөлтийн нэгжид Монгол дахь гуравдагч хөршийн бүтээн байгуулалтыг хэт хардсан, буруугаар төсөөлсөн, тэр хэрээрээ хожим цэргийн ажиллагаа явуулах объект гэж үзсэн элдэв алхмууд хийсээр байна. Үүнд “Оюутолгой” бол өрнөдийн, НАТО-гийн орнуудын хөрөнгө оруулалт, түүнийгээ цэргээр хамгаалуулах магадлалтай, тийм явдал гаргуулахгүй байх хувилбарыг боловсруулж газрын зураг дээр тоглолт хийж байна. Хөшгийн хөндийн олон улсын аэропортын бүтээн байгуулалтыг Японы хөрөнгөөр босч буй НАТО-гийн аэродром хэмээн Оросын цэргийн мэргэжилтнүүд үзсээр байна⁵⁹.

“Хааны эрэлд” олон улсын энхийг сахиулах хүчний хээрийн сургууль, үүнд Америкийн цэргийн оролцоог харддаг. Сүүлдээ энэ хээрийн сургуульд Хятад өөрийн баг цэргээ оролцуулж дотроос нь

57 Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, Хавсралт
58 С.Баяр: Суусан газраасаа чулуу агта, <http://prnews.mn/news/2017.05.25>
59 Хурандаа Ж.Амгалантай хийсэн аман түүх-ярилцлага, зохиогчийн хувийн архив

ажиллах, Орос ажиглагчаа ирүүлж ажилладаг хэлбэрт шилжиж байна⁶⁰. Энэ тухай зохиогч би АНУ-ын Батлан хамгаалахын сайдын 2014 оны айлчлалын үеэр хэвлэлд ийнхүү ярилцлага өгч байсан болно. Үүнд:

- Миний ажигласнаар албан бус байдлаар манай талд анхааруулах, сэтгэл түгших явдал эхэндээ байсан байх. АНУ дэлхийд цэрэг-улс төр, эдийн засгийн чадавхийг ноёрхох бодлого явуулж, энэ зорилгоор Орос, Хятадын эргэн тойронд өөрсдийн ашиг сонирхол, байр сууриа бэхжүүлээ гэж хоёр хөрш маань хүлээн авсан тал бий.
- Орос, Хятадын завсарт орших стратегийн онцгой байршилтай Монголын орон зайд үйл ажиллагаа явуулж эхлэх нь гэж хардсан ч байх.
- Монгол дахь Орос, Хятадын нөлөө, байр суурийг бууруулах, улмаар аль нэг хөршийнх нь эсрэг байр суурийг дэвэргэх нь гэж эмзэглэсэн ч байх.
- Ийм эмзэглэлийг манай тал ч АНУ-ын тал ч ойлгож, цэргийн харилцааг аажмаар бэхжүүлэх, чингэхдээ АНУ-аас бусад хөгжиж буй улстай харилцаж буй хэмжээнд хадгалах сонирхолтойгоо удаа дараа илэрхийлсэн байдаг юм билээ.
- АНУ-ын албаны хүмүүсийн байнга хэлдэг зүйл бий л дээ. “АНУ-аас Монгол Улстай хөгжүүлж буй цэргийн харилцаа нь Монголоос хоёр хөрштэйгээ хөгжүүлж буй харилцаанд сөрөг байдлаар нөлөөлөхгүй ээ” гэж. Манай улстай хөгжүүлж буй цэргийн харилцаа нь зөвхөн энхийг сахиулах, байгалийн гамшигтай тэмцэх, зэвсэгт хүчний хүчин чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэж байгааг онцолж, харилцааг энэ хүрээндээ халиахгүй байхад АНУ-ын талаас байнга анхаарч ирсэн шүү дээ.
- Гэхдээ энд Монгол нь хоёр хөрш улстайгаа батлан хамгаалах салбарт цэргийн найрсаг хамтын ажиллагаа хөгжүүлж ирснийг тэмдэглэх нь зөв байх. Оросын хувьд бас өөр тайлбар хэлж баримт дурдаж болох юм. НАТО-ын нөлөө бүхий

гишүүн АНУ тус улсын эргэн тойрны бүс нутагт цэргийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж, өмнө нь СССР-ийн бүрэлдэхүүнд байсан Балтийн гурван улсыг НАТО-гийн гишүүн болгож, ТУХН-ийн ихэнхи оронтой цэргийн харилцаа тогтоосонд ОХУ тааламжтай бус байгаа нь ойлгомжтой. Нөгөө талаас ОХУ-ын сонирхол буурсан, эдийн засаг хүндэрсэн зэргээс үүдэн манай армийн уламжлалт зэвсэг, техникийн шинэчлэл, боловсон хүчнийг сургалт боломжгүй болсон учраас цэргийн сургалт тасралтгүй байх, орчин үеийн зэвсэг техниктэй болох манай дотоодын эрэлт хэрэгцээг ОХУ-д арга буюу ойлгосон, гэхдээ өөрөөр хандсан гэж үзэж болохоор. Өмнөх 70 гаруй жилийн Монгол-Зөвлөлтийн ах дүү армиудын холбоотны хэмжээний хамтын ажиллагаагаа Орос улс өнөөдөр АНУ-д алдчихгүй байхын тулд бололцоотой бүхий л арга хэрэглэсэн. Жишээ нь Ирак дахь эвслийн ажиллагаанд Монгол Улс нэгдсэний дараахан Орос-Монголын батлан хамгаалах салбарын харилцаа идэвхжсэн, Сибирийн цэргийн тойрогтойгоо хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж манай талд олгосон зэргээр мартагдах шахаж байсан харилцаагаа сэргээхийг зорьсон явдал бий.

- БНХАУ-ын хувьд Монгол-Америкийн цэргийн харилцааг болгоомжилсон, зарим талаар хардангуй өнгө аясаар харж хандаж байдаг тал бий. Ганц АНУ ч гэлтгүй, НАТО-гийн Энхийн төлөө түншлэлд ч тэгж хандаж байсныг би сайн мэдэх юм. Хятадын судлаачдын байр суурийг ажваас, мөн хятадын судалгааны зарим хэвлэлд хоёр янзын ерөнхий дүгнэлт харагддаг. АНУ нь Энэтхэг, Вьетнам, Казахстан, Монгол зэрэг БНХАУ-тай хил залгаа улс орнуудтай стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж, Хятадын эргэн тойронд байр сууриа бэхжүүлэх нь гэж хардсан, нөгөө нь Монголд АНУ-ын цэргийн бааз, сургалтын төв байгуулж, Хятадыг ар шилэн дээрээс нь тагнах нь гэж хардсан тал харагддаг. Зун болгон Монголд хамтран зохион байгуулж буй “Хааны эрэлд” сургуулийг “Дэлхийн энхийг дэмжих ажиллагааны санаачилга” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа

⁶⁰ Хоёр орны батлан хамгаалах салбарт хамтран ажилласны хүрээнд нэг үе шатны айлчлал болов уу, “Өдрийн сонин”, № 091 (4731) 2014.04.14

бүс нутгийн анхны томхон дадлага сургууль гэдгийг хятадын талд сайтар тайлбарлаагүйгээс, мөн дээхнэ Тайванийн нэгэн хэвлэлд нийтлэгдсэн “АНУ Монголтой хамтран Хятадыг тагнах үйл ажиллагаа явуулж байгаа” гэх мэдээллийг тухай бүрт нь бид няцаагаагүйгээс Хятадын болгоомжлол, эмзэглэл даамжирсан тал бий. Гэлээ гээд Хятад нь манай улстай хөгжүүлсэн хоёр талын харилцаагаа ахиулснаас бус бууруулаагүй. Цэргийн салбарт бүр ч илүү нягт хамтран ажиллахыг зорьж байна. Сүүлийн үед батлан хамгаалах салбарт буцалтгүй тусламж олгох, цэргийн айлчлал, солилцоо, сургалтыг өргөжүүлэхэд Хятадын тал анхаарах болсныг бид баяртайгаар дэмжиж байгаа шүү дээ⁶¹.

Ийм хардлагуудын эсрэг Монгол Улс өөрийн бодлого байр сууриа ил болгож, илээр зарлаж, олон улсын хамтын нийгэмлэгт хүргэж байж “гуравдагч хөршийн бодлого” явуулах ёстой.

Цэргийн хамтын ажиллагааг хөшүүрэг болгох арга зам энд нээлттэй байна. Манай “гуравдагч хөршийн бодлого”-ын нэг тод илэрхийлэл нь ийнхүү цэргийн хамтын ажиллагаа байх бүрэн боломжтой ба одоо ч яг тийм болчихоод байна. Харин тэрхүү хамтын ажиллагаагаа хоёр хөрштэй харилцахдаа хэрхэн хөзөр болгон ашиглах вэ гэдэгт асуудлын гол нь оршино. “Хааны эрэлд” сургуульд Хятадын тал цаашид томхон багаар оролцох магадлалтай. Хятад нь манай улстай цэргийн салбарт бүр ч илүү нягт хамтран ажиллахыг зорих болсон. Батлан хамгаалах салбарт буцалтгүй тусламж олгох, цэргийн айлчлал, солилцоо, сургалтыг өргөжүүлэхэд Хятадын тал анхаарч ирснийг бид олзуурхах ёстой. Энэ бол манай хөзрийн нүүдэл зөв байсныг илтгэнэ.

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын гурван талт уулзалт 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Токио хотноо болсон. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын гурван талт уулзалт нь бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагаа, харилцан ашигтай эдийн засгийн хөгжлийн асуудлаар санал солилцох чухал механизм⁶² болж байгаагийн ач холбогдлыг талууд дахин нотложээ.

⁶¹ Мөн тэнд

⁶² Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын хамтарсан мэдэгдэл, <http://www.mfa.gov.mn>

Хөгжлийн замаа бусдын албадлагагүйгээр бие даан сонгох эрхээ нийт улс орнууд нь эдэлж чадах, амар амгалан, хөгжин цэцэглэсэн Энэтхэг, Номхон далайн бүс нутгийн талаарх өөрсдийн төсөөллөө уулзалтын үеэр Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улс тодорхой танилцуулав. Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын дагуу Монгол Улстай хоёр талын харилцаагаа өргөжүүлэх эрмэлзлэлээ Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улс нотлож, Ази Номхон далайн бүс нутаг даяар хэлхээ холбоо, сайн засаглал, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд суурилсан эмх журмыг хөхиүлэн дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжуудын талаар гурван улс санал солилцжээ.

Солонгосын хойгт сүүлийн үед өрнөж буй нааштай үйл явцыг гурван тал сайшаав. Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс бүр мөсөн, хяналттайгаар, эргэлт буцалтгүйгээр ангижруулах асуудлыг баталгаажуулах зорилгоор Умард Солонгост үзүүлж буй дэлхийн нийтийн шахалтыг үргэлжлүүлэх, түүний дотор НҮБ-ын АЗ-ийн холбогдох бүх тогтоолыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн төлөө байгаагаа тэд дахин нотлосон ба хулгайлагдсан иргэдийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх зэрэг хүмүүнлэгийн асуудлуудад анхаарал хандуулахын чухлыг гурван улс онцлон тэмдэглэжээ.

НҮБ-ын энхийг сахиулах болон дэлхийн мөргөлдөөнт бүсүүдэд тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ажиллагаанд оруулж буй Монгол Улсын хувь нэмрийг Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улс өндрөөр үнэлэв. Гурван тал болон олон талын хүрээнд аюулгүй байдал, энхийг сахиулах чиглэлээрх хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар санал нэгтэй байгаагаа оролцогчид дахин нотлов. Мөн олон талт хамтын ажиллагааны бүтэц, байгууллага, эвсэл, тухайлбал АОХН, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн хүрээнд нийтлэг үнэт зүйлс, олон улсын эрх зүйн хэм хэмжээг дэмжих үүднээс өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихээ талууд батлан гаргажээ.

Харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа нь гурван талын харилцаанд чухал байр суурь эзэлсэн хэвээр байна. Талууд худалдааг нэмэгдүүлэх, Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчныг Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улсын аж ахуйн нэгжүүдэд илүү таатай болгох, ялангуяа ил тод, тогтвортой байдлыг сайжруулах боломжийн талаар санал солилцсон.

ОУВС-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн дэмжлэгээ үргэлжлүүлэх эрмэлзэлтэй байгаагаа Япон Улс дахин нотолж, төсвийн хариуцлагыг сайжруулах талаар авч буй хүчин чармайлтаа Монгол Улс цаашид тогтвортой хадгална хэмээн итгэж байгаагаа илэрхийлэв. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал нь Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны билэг тэмдэг болохуйц бөгөөд Монгол Улс болон улсын хоорондын харилцаа холбоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болохыг японы тал дахин тэмдэглэв. Монгол, Япон хоёр улс Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг аль болох ойрын хугацаанд ашиглалтад оруулах явцыг шуурхайлах талаар хамтын хүч чармайлт гаргахаар тохиролцсон.

АНУ нь Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх тухай Мянганы сорилтын корпораци, Монгол Улсын Засгийн газрын хооронд Хоёр дахь компакт гэрээг байгуулах эрмэлзэлтэй байгаагаа нотлов. АНУ нь Олон улсын тусламжийн агентлагийн санхүүжилтээр “REACH” хөтөлбөрийн хүрээнд Монголын жижиг, дунд үйлдвэрлэгчдэд зээлийн боломжийг нээж, “LEAD” хөтөлбөрийн хүрээнд Монголын шинэ үеийн ардчиллын манлайлагчдын хөгжлийг дэмжсэнээ тус тус тэмдэглэсэн.

Түүнчлэн мөнгө угаах, терроризм болон үйлдвэр хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын чадавхийг бэхжүүлэхэд мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр Ази Номхон далайн бүсийн бүлгээс өгсөн зөвлөмжийг Монгол Улс бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн чухлыг тэмдэглэн энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар оролцогч талууд санал солилцсон байна.

11. Дүгнэлт

Манай “гуравдагч хөршийн бодлого” өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд буй болж, хэрэгжиж, одоо төлөвших шатандаа байна. Цаашид энэ бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл, боломж, нийгмийн сэтгэхүй бүрдэж байна.

“Гуравдагч хөршийн бодлого” бол манай улсын геостратегийн ач холбогдлыг өсгөж, Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын нийгэмлэгт манай улсын эзлэх байр суурь, хамаарлыг нэмэгдүүлэхэд

тус дэм болж байгаад гол ач холбогдол нь оршино.

“Гуравдагч хөршийн бодлого” нь хоёр их хөршөөс манай улсад хандах хандлагыг муутгах бус, сайжруулах чиглэлээр төлөвшиж байна. Энэ зөв чиглэл, түүний давуу талыг алдахгүй байх нь чухал юм.

Шинэ Ерөнхийлөгч Х.Баттулга үүрэгт ажилдаа ороод гадаадын өндөр дээд хэмжээний эхний хүндэт зочноороо Японы парламентын Төлөөлөгчдийн танхимын спикерийг хүлээн авсан, мөн Берлин хотын Засаг даргыг айлчлуулсан, гадаад улсад анх удаа Унгарт ажлын шугамаар айлчилсан, Владивостокийн Дорнын эдийн засгийн форумд оролцоходоо Японы Ерөнхий сайд, БНСУ-ын Ерөнхийлөгчтэй уулзсан зэрэг нь “гуравдагч хөршийн бодлого”-ын ил тод, эргэлтгүй байр суурийн илэрхийлэл болж чадсан гэж үзэж байна.

2009 онд өмнөх Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Энэтхэгээс айлчлалаа эхэлж байсныг харгалзан үзсэн тал ч байсан байж болно.

“Гуравдагч хөршийн бодлого” бол “гуравдагч хөрш” гэгдэх тэдгээр улс орнуудаас манай улстай тогтоосон харилцааны өвөрмөц хэлбэр гэдгийг хоёр хөршдөө хойшид ч ямагт ойлгуулж, сурталчилж байх нь чухал юм. Өрнө-дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдээс бүс нутгийн хөгжиж буй бусад улс орнуудтай хөгжүүлж буй нэгэн хэвийн тогтсон харилцаанаас Монгол руу хандуулсан тэр бодлогыг нь ялгаруулан, тодорхой түвшинд, харилцан ашигтай байдлаар цааш хөгжих нөхцөл бүрдүүлэхийн төлөө бид ажиллах ёстой болов уу.